



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



Food and Agriculture
Organization of the
United Nations



GLOBAL AGENDA FOR
SUSTAINABLE LIVESTOCK

МАЛ АЖ АХУЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ ЧАДАМЖИД СУУРИЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР



ХӨДӨӨ АЖ АХУЙН ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН ТӨВ ТББ



МОНГОЛ УЛСЫН МАЛ АЖ АХУЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



АГУУЛГА

БҮРЭЛДЭХҮҮН

1	ТАНИЛЦУУЛГА	Хуудас
01	ТАНИЛЦУУЛГА	01
02	СУДЛАГДСАН БАЙДАЛ	05
03	АРГАЗҮЙ	06
04	ХЭРЭГЛЭЭ	07

БҮРЭЛДЭХҮҮН

2	ЧАДАМЖИД СУУРИЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР	
05	ХӨТӨЛБӨРИЙН БҮТЭЦ	08
06	ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ	41
07	ТАЛАРХАЛ	43
08	АШИГЛАСАН ХЭВЛЭЛ	44

ТАНИЛЦУУЛГА

Монголчууд олон мянган жилийн тэртээгээс өвлөгдөн ирсэн бэлчээрийн мал аж ахуйн соёл, уламжлалтай ард түмэн бөгөөд нийгэм, эдийн засагт нь мал аж ахуйн салбар томоохон хувь нэмэр эзэлдэг хөгжиж буй орнуудын нэг юм. Хүн амынх нь тал орчим хувь нь мал аж ахуйгаас шууд хамааралтай аж төрдөг.

Монголын нийгэм зах зээлийн тогтолцоонд шилжсэн 1990-ээд оноос хойш мал аж ахуйн салбар нь байгаль цаг уур, нийгэм эдийн засгийн хүндрэлтэй асуудлуудтай тулгарсан. Бэлчээрийн аж ахуйн системд газар, усны нөөц ашиглалт, эдийн засаг, улс төрийн болон нийгмийн тэгш бус байдал, малын эрүүл мэнд, зоонозын өвчлөл¹ зэрэг зүйлүүдтэй Монгол малчид тулгарах болсон.



Тулгамдаж буй асуудал:

- А Монгол орон даяар дулаарал, хуурайшилт явагдаж ган, зуд зэрэг байгалийн сөрөг үзэгдлийн давтамж нэмэгдэж байна.
- Б Үр өгөөж багатай бэлчээрийн менежментийн тогтолцоо алдагдаж байна.
- В Малын хэт өсөлт, талхагдал нь бэлчээрийн доройтол руу хөтөлж байна.
- Г Хотжилт эрчимжиж нүүдлийн мал аж ахуйн соёлыг өвлөх малчдын залгамж халаа цөөрсөн.
- Д Уламжлалт мал маллагааны арга барил орхигдож байна.
- Е Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицсон тогтвортой бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нэвтрүүлэх үйлчилгээний хөгжил сул байна.



Хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хурдацтай хөгжилд малчдыг хэрхэн бэлтгэх бэ?

¹https://ec.europa.eu/knowledge4policy/sites/know4pol/files/hlpe-report-10_en.pdf



Монгол Улсын нүүдлийн мал аж ахуйн болон бэлчээр ашиглалтын зохицуулалт нь бэлчээр ашиглалтын уламжлалт арга, улс төр эдийн засгийн тогтолцооны өөрчлөлттэй шууд хамааралтай хөгжиж ирсэн. Түүхэн товчноос үзэхэд мал аж ахуйн болон бэлчээр ашиглалтын харилцааг хошуу тамгын ноёд зохицуулж ирсэн байхад сүүлд төлөвлөрсөн тогтолцоот нийгмийн үед засгийн газар зохицуулж байсан. Энэхүү төвлөрсөн тогтолцоот нийгэм нь 1990 оны эхээр нээлттэй эдийн засаг бүхий ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжихэд бүхэлдээ нуран унасан.

“

Малчдын амьжиргаа нь малаас шууд хамааралтай, нийгэм эдийн засгийн болон хүрээлэн буй орчны эрсдэлтэй тулгардаг тул Улс төр, эдийн засгийн шинэ нөхцөл байдалд ашиг орлогоо (мөнгөн болон мөнгөн бус) нэмэгдүүлэхийн тулд эдийн засгийн хувьд өгөөжтэй мал сүргийн тоог нэмэгдүүлэх арга замыг эрэлхийлж байна. Энэ нь бэлчээрийн даац хэтрэлт, байгаль орчны доройтол зэрэг урт хугацаандаа нүүдлийн мал аж ахуйн оршин байхад сөрөг нөлөө үзүүлэх суурь нөхцөлийг үүсгэж байна.

МОНГОЛЫН МАЛ МАЛЛАГААНЫ ТОВЧ ТҮҮХ

Монгол Улс нь 2000-3000 жилийн нүүдлийн мал аж ахуйн баялаг түүхтэй дэлхий дээрх цөөхөн улсуудын нэг юм. Мал аж ахуй нь түүхэн хөгжлийн бүхий хугацаанд эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны хувьд чухал ач холбогдолтой салбар хэвээр байсаар байна.





Мал аж ахуйн тогтвортой хөгжлийн төлөвлөгөө² бодлогын зорилтыг орон нутагт хэрэгжүүлэх, малчдын түвшинд практик байдалд бүүлгахыг төслийн багийнхан зорьсон. Энэ зорилгын хүрээнд бид арвин туршлага бүхий аж ахуй нэгжүүдийг нэгтгэж, малчид, гадаад дотоодын эрдэм шинжилгээний ажилтан, тариаланч, малын эмч, агрономич, мал аж ахуйн бодлого боловсруулагчид гэх мэт мал аж ахуйн мэргэжилтнүүдтэй холбоо тогтоохыг чухалчилсан. Тэдний хүчин чармайлтын тусламжтайгаар Монгол Улсын мал аж ахуйн хөгжлийн цөм болно гэж үзсэн бол чадамжуудыг гарган ирсэн.


Энэ нь Монголын малчдад зориулсан чадамжид суурилсан хөтөлбөр боловсруулах гэж оролдсон анхны бүтээл юм. Малчдын оролцоотойгоор “бодит байдалд³ тулгуурлах” зарчмаар энэ чадамжуудыг хөгжүүлсэн. Монгол орны бэлчээрийн мал аж ахуйн хэлбэр үйл ажиллагаа нь дэлхий дахинаа төдийгүй Монгол орны бүс нутагт тохирсон цогц зүйл биш хэдий ч ирээдүйд малчдын хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилтэд ашиглах үндсэн суурь болно гэж бид үзэж байна. Үүнтэй холбоотой хөтөлбөр нь ерөнхийдөө дараах зарчимд суурилна.

Зарчим




СУРАЛЦАХУЙ

Суралцахуй нь өөрийгөө удирдан чиглүүлж, асуудалд суурилсан насанд хүрэгчдийн сурах зарчимд нийцүүлэн явагддаг.



МАЛ МАЛЛАХУЙ

Мал сүрэг болон газар нутгийн байдал нь суралцахуйн үндэс болох нь.



ТАНИЛЦАХУЙ

Танилцахуйд суурилсан сургалтын хэрэгслээр сониуч байдал болон шинэлэг байдлыг өдөөхүй.



СУРГАХУЙ

Тусгайлан бэлтгэгдсэн зааварлагчид сургах үйл явцад заах бус сурах үйл явцыг хялбаршуулах аргаар туслах.

Энэхүү бүтээл нь оролцоонд суурилсан суралцахуйн замаар нэгтгэсэн мэдлэг% инновацад тулгуурласан. Уг хөтөлбөр нь цаашид шинэчлэгдэн, сайжруулагдаж байх шаардлагатай.

²Дараах линкээр болбогдох боломжтой <http://masl.mofa.gov.mn>

³Жишээ нь: Farmer field schools for small-scale livestock producers (FAO, 2018).


Хурдтай өөрчлөгдөж буй орчин нөхцөлд малчдыг хэрхэн бэлтгэх, түүнтэй холбоотой сорилтууд нь энэхүү бүтээлийн гол асуулт байв. Олон аж ахуйн нэгжүүд болон тэдгээрийн өөрсдийн стратегиуд нь хэдийнээ тогтвортой мал аж ахуйн салбарын тогтвортой байдлыг бодлогын түвшинд хөгжүүлэхээр шийдсэн байдаг боловч бодит байдалд дээрээ тогтвортой байх нөхцөлийг олгодог малчдын үндсэн чадамжийн талаар нэгдсэн ойлголт байхгүй байгаа байна. Бидний хүчин чармайлтын үндэс суурь нь Тогтвортой мал аж ахуйн даян дэлхийн хөтөлбөр (GASL) -ийн дэмжлэгтэйгээр олон талт оролцогсдын хүч хөдөлмөрөөр боловсруулсан өндөр түвшний үйл ажиллагааны төлөвлөгөө болох Монгол

Улсын тогтвортой мал аж ахуйн хөтөлбөр (MASL) юм. Уг үйл ажиллагааны төлөвлөгөөг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам баталж, 2018 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөө нь мал аж ахуйн тогтвортой байдлыг бодлогын түвшинд тодорхойлох ба НҮБ-ын 2030 Хөтөлбөрийг хүрэн дэх дэлхийн болон орон нутгийг мэдлэгийг нэгтгэн анх удаа гарган ирснээрээ онцлог юм. Уг төлөвлөгөөнд олон талын хамтрагч байгууллагууд нэгдсэн. Үүнд: МЭЕГ, НҮБ-ХБ, ХХААБ, НҮБ-ХБ, ХААХОУС, ШХА, ГОУХАА, ДБ, АХБ, ЯОУХАА, ТННХ, МКМ, ХААИС, ХААХҮСХТ, БАНХ, ЗААХН, ДЗААХС, БСТ, ДБОС, СОУХАА, УАНС, ВЕТНЕТ, ХААТХТ.



СУДЛАГДСАН БАЙДАЛ

Малчдын боловсролын талаар одоогийн байдлаар нийт 42 төрлийн сургалтын байгууллага байгаагаас 9 нь төрийн өмчийн байгууллага, 25 нь мэргэжлийн холбоод, төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллага байсан ба олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд 8 төсөл хэрэгжсэн байна. Эдгээр байгууллагууд нь бүгд өөр өөр түвшинд сургалт явуулдаг.



60% Төрийн бус байгууллага;

21% Төрийн байгууллага;

19% Олон Улсын байгууллагуудын төсөл хэрэгжүүлэх нэгж

Хэрэгжүүлсэн сургалт нь улирлын шинжтэй, тогтмол бус, ихэнх нь туршилтын сургалт хэлбэрээр буюу зөвхөн төсөл, хөтөлбөр, иргэдийн тодорхой нэг хэсэгт чиглэсэн чанартай болсон. Бидний судалснаар 42 сургалтын байгууллага судлагдсан бөгөөд техник, мэргэжлийн сургалтын төв, политехникийн коллеж, зарим хувийн компани, төрийн бус байгууллага зэрэг 22 байгууллага нь мэргэжлийн болон бизнесийн сургалт явуулж, үр чадварын гэрчилгээ олгодог байна. Үлдсэн 20 аж ахуй нэгж нь сургалтын гэрчилгээ олгодоггүй боловч малчид, орон нутгийн иргэдэд мал аж ахуйн салбарын мэдлэг, үр чадвар эзэмшүүлэх богино хугацааны сургалт явуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг хөдөлмөр халамжийн ерөнхий газар нь 21 аймаг, 9 дүүрэг дэх салбаруудаар дамжуулан залуу малчдад зориулсан чадвар эзэмшүүлэх богино хугацааны сургалт явуулдаг төрийн байгууллага юм.

Насан туршийн боловсролын үндэсний төв нь 19 аймгийн 328 сум, нийслэлийн 8 дүүрэгт салбартай бөгөөд малчид, орон нутгийн иргэдэд олон сэдвээр амьдралын боловсрол эзэмшүүлэх сургалтыг явуулж байна.

Хөдөө аж ахуйн судалгаа, хөгжлийн төв нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа байгууллага тул хөдөө аж ахуйн нэвтрүүлэх үйлчилгээг Улсын хэмжээнд хэрэгжүүлдэг байгууллага юм. Уг судалгаа, хөгжлийн төв нь орон нутаг дах төлөөлөгчдөөрөө дамжуулан малчдад зориулсан гарын авлага, зөвлөмж, ном сурах бичгийг тарааж хүргэдэг.

Техник мэргэжлийн сургалтын төв болон политехникийн коллеж нь бүх аймгуудад салбартай мэргэжлийн боловсрол олгох сургалтыг явуулдаг. Энэ байгууллага нь малчид, фермерүүдэд зориулсан урт хугацааны сургалт явуулж мэргэжлийн сургалтыг танхимын болон дадлага хэлбэрээр зохион байгуулдаг. Ийм төрлийн сургалтыг мөн **Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуй, биотехнологийн сургууль** зохион байгуулж байна. Энэ төрлийн сургалтад хамрагдаж байгаа суралцагчид нь насны ялгаатай цэргийн байгууллагад ажиллаж байсан эсвэл өөр салбараас мал маллахаар шийдсэн зэрэг харилцан адилгүй боловсролын болон туршлагын түвшинтэй хүмүүс байдаг. Олон Улсын байгууллагууд нь хэрэгжүүлж буй төслийнхөө хүрээнд малчдад зориулсан мал аж ахуй, байгаль орчин, хувь хүний хөгжлийн мэдлэг олгох богино хугацааны сургалтыг зохион байгуулдаг.

Дээрх сургалтууд нь бэлчээрийн менежмент, малын эрүүл мэнд, тэжээл тэжээллэг, эрчимжсэн мал аж ахуй зэрэг сэдвээр малчдын мэдлэг сайжруулах зорилготой. Эдгээрээс цөөхөн хэд нь өрхийн бизнес эрхлэлт, жижиг дунд бизнес эрхлэлт, мал үржүүлгийн чиглэлийн сургалтыг нэмэлтээр зохион байгуулж байна.

АРГАЗҮЙ

Энэхүү сургалтын хөтөлбөрийг малчид, мал аж ахуйн тогтвортой хөгжлийн төлөвлөгөөний хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудад түшиглэн оролцооны аргаар боловсруулсан. Уг хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг, гэрээ нь 2020 оны долодугаар сараас эхлэлтэй бөгөөд есөн чадамж эзэмшүүлэх сэдэвтэй байхаар санал нэгдсэн. Эдгээр сэдвүүд нь тогтвортой хөгжлийн зорилтууд, Монгол Улсын мал аж ахуйн салбарын бодлогын баримт бичгүүдтэй нягт уялдаж байна.

Түүнчлэн сургалтын хөтөлбөрийг боловсруулагчид дэд сэдвүүдэд задлан, тэдгээрийн хүрээнд малчдад эзэмшүүлэх, чадамжийг шалгах гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт⁴-ийг тодорхойлсон. Чадамжийг шалгах гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг төлөөлж буй хэмжигдэхүйц, ялгагдахуйц үйл үгнүүдийг Блүүмийн таксономи⁵-д үндэслэсэн. Хөтөлбөрийг Завхан аймгийн Идэр сумын малчидтай хэлэлцсэний үндсэн дээр мал аж ахуйн зөвлөх мэргэжилтнүүдтэй хамтран хурлаар оруулан хэлэлцүүлсэн.

ХАМРАХ ХҮРЭЭ

Нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдэд⁶ зориулсан тусгай сургалтын хэрэгцээ нь нийгмийн шаардлага болон гарч ирж байна. Уг төсөл нь дан ганц мал аж ахуйн салбарыг хамраад зогсохгүй малчдын нийгмийн асуудал, эрүүл мэнд, өрхийн санхүү зэргийг хамарсан хөтөлбөр бөгөөд бүх насны малчдад зориулснаараа онцлогтой. Нүүдлийн мал аж ахуй эрхлэлт нь өнөөг хүртэл уламжлалт хэв шинжээ хадгалан хөгжиж байгаа учир механик ажиллагаа их хэвээр тул гэр бүлийн гишүүд (эрэгтэй, эмэгтэй, хүүхэд) төдийгүй айл хотлоороо хөдөлмөрөө хоршин ажиллах шаардлагатай болдог. Төслийн материалын төгсгөлд хавсаргасан тайлбар толийн хэсэгт

дурдсанчлан нүүдлийн мал аж ахуй эрхлэлтийн талаарх ойлголт өөрчлөгдөж, шинэ ухагдахуун нэмэгдэн орж байна. Амьдралын хэв маяг өөрчлөгдөж суурин байдалд шилжиж байгаатай холбогдуулан энэ нэр томъёоны талаар маргаан их байдаг хэдий ч бид суурин орчинд шилжиж буй нүүдлийн мал аж ахуйн өөрчлөгдөж буй орчинд⁷ дасан зохицох явдал хэмээн үзэж байна. Тогтвортой байдлын болон Агро-Экологи⁸-ийн арван бүрэлдэхүүн хэсэг, түүнчлэн Нэг Эрүүл Мэнд хөтөлбөр болон Хүнсний Аюулгүй Байдал⁹ үндэсний хөтөлбөрийн Газар, Ой, амьтны нөөцийн эдэлбэрийн хариуцлагатай засаглалын сайн дурын зөвлөмжүүдийг харгалзан үзсэн.

⁴Судлаачид гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд нь дэлгэрэнгүй байх албагүйг мэдсэн. Бид тэдгээрийг эхлэх цэг гэж үзэж, нийтлэг ойлголтыг хангах, холбогдох сургалтын материалыг боловсруулахад дөхөм болгох зорилгоор тодорхой жишээ, эх сурвалжийг ашигласан болно.

⁵<http://www.northeastern.edu/nuolirc/wp-content/uploads/2018/01/Blooms-Taxonomy-Handout.pdf>

⁶Жишээ нь боловсролын хүртээмж, хүнсний хэрэглээний хэв маягийг өөрчлөх, Хөдөлгөөнт байдал, эрүүл мэндийн үйлчилгээ гэх мэт). Сэдэвтэй холбоотой танилцуулгыг эндээс илүү ихийг уншина уу

<https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000232422>

⁷"Өөрчлөгдөж буй орчин" гэдэг нь ийм байдлаар өгөгддөггүй, харин "хүний" сонголтоос үүдэлтэй гэдгийг бид онцолмоор байна. Үүний тухай дэлгэрэнгүй мэдээллийг Каролин Хамфри, Дэвид Снит нарын 1999 онд хэвлүүлсэн "нүүдэлчдийн төгсгөл" судалгаанаас харж болохоор байна. <https://www.dukeupress.edu/the-end-of-nomadism>.

⁸Агро-экологи нь хүнс, хөдөө аж ахуйн системийн менежмент болон төлөвлөгөөнд экологи, нийгмийн үзэл баримтлал, зарчмуудыг нэгэн зэрэг ашигладаг нэгдсэн ойлголт юм.

<http://www.fao.org/documents/card/en/c/19037EN>

⁹<http://www.fao.org/cfs/home/activities/vggt/en/#:~:text=The%20Voluntary%20Guidelines%20on%20the,povearty%2C%20supporting%20sustainable%20development%20and>

ХЭРЭГЛЭЭ

Бид хүн бүрийг энэхүү сургалтын хөтөлбөр дэх эдгээр чадамжийн талаарх өөрсдийн туршлагаасаа хуваалцан, оролцсоноор мал аж ахуйн салбарын хөгжилд хувь нэмрээ оруулсан болно хэмээн үзэж байна.

Эдгээр чадамжийг өөрсдийн шаардлагатай нэгтгэн олон улсын тогтвортой мал аж ахуйн салбарын аттестатчилалд ашиглах боломжтой.



Түүнчлэн энэхүү загварыг

- бүх салбарын удирдлагууд,
 - бодлого боловсруулагчид,
 - боловсролын байгууллагууд,
 - хувийн байгууллагууд
 - төрийн бус байгууллагууд
- ашиглах боломжтой ба дараах нөхцөлөөр ашиглана.

Ажиллах хүчний хөгжил: Малчдын чадамжийн стандартчилсан лавлагаа болгох.

Хөтөлбөрийн хөгжил: Малчдад чиглэсэн хөтөлбөрт суралцах үндэс суурь болгох.

Ажлын байрны тодорхойлолт: Стандартчилагдсан ажлын байрны тодорхойлолт бичих.

Хэрэгцээний үнэлгээ: Хувь хүн эсвэл бүлгийн хэрэгцээг тодорхойлох, боловсон хүчний хөгжлийн төлөвлөлтийг удирдан чиглүүлэх, өөрийгөө үнэлэх, ажиглагчийн үнэлгээ эсвэл хоёуланд нь хослуулах арга хэрэгслийг боловсруулах удирдамж болгох.

Өөрийгөө үнэлэх: Хувь хүмүүс (малчид, сургагч багш нар, мал аж ахуйн мэргэжилтнүүд гэх мэт)-ийн мэдлэг, чадвар, дадлын өнөөгийн түшинг үнэлэх, сайжруулах, шаардлагатай хэсгийг олж тогтоох, илүү өндөр түвшний чадвартай болгох.

¹⁰Мэдлэг хуваалцах соёл гэдэг нь жижиг бизнес эсвэл зохион байгуулалттай хамт олон байхаас үл хамааран байгууллагын, хоршооны нэг үгээр шар тос юм. <https://www.knowledgebase-script.com/kb/article/how-to-encourage-knowledge-sharing-at-workplace-214.html>

ХӨТӨЛБӨРИЙН БҮТЭЦ

ЧАДАМЖУУД

1		Байгалийн нөөцийн ашиглалт
2		Бэлчээрийн ашиглах
3		Мал маллах
4		Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах
5		Дэвшилтэт технологи, арга барил ашиглах
6		Хувийн аж ахуй эрхлэгч болох
7		Хамтын харилцааг хөгжүүлэх
8		Эрсдэлийг удирдах
9		Дэлхийн хэмжээнд сэтгэхүй

Сургалтын хөтөлбөр нь дараах бүтэцтэй байна.

ҮНДСЭН ЧАДАМЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ:

Даалгаврыг үр дүнтэй явуулахад шаардлагатай мэдлэг, ур чадвар, дадлын нэгдмэл юм. (жишээ нь “1. Байгалийн нөөцийн ашиглалт”).

СЭДЭВ:

Чадамжийн бүрэлдэхүүн хэсэг (жишээ нь: “ус”).

ДЭД СЭДЭВ:

Сэдвийн дэд бүрэлдэхүүн хэсэг (жишээ нь: “усны эргэлт”).

ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Тухайн нөхцөл байдалд даалгавар гүйцэтгэх мэдлэг, ур чадвар, хандлагын нэгдсэн хослолыг ашиглах чадвар.



ЧАДАМЖ 1

БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАХ

Хөрс, усны болон шимт бодисын эргэлтийг тооцон байгалийн нөөцийг тогтвортой ашиглах мэдлэг, чадвар, чадамжийг эзэмшүүлэх. Байгалийн нөөцийг дэд бүтцийн хөгжил, цаг уурын өөрчлөлт болон тогтвортой хөгжлийн зарчимд нийцүүлэн ашиглахыг хамааруулна. Бэлчээр ашиглалтын тухай чадамж-2 хэсэгт орсон болно.

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
1.1 Нөөц ашиглалтын зарчмууд	1.1.1 Байгалийн нөөц	<ul style="list-style-type: none"> a. Байгалийн нөөц гэж юу бэ? Жишээ хэлэх; b. Нөхөн сэргээгдэх ба нөхөн сэргээгдэшгүй байгалийн нөөцийг ялгах; c. Малчдын хувьд аль байгалийн нөөц нь хамгийн чухал болохыг тайлбарлах.
	1.1.2 Экосистем	<ul style="list-style-type: none"> a. Экосистем гэдгийг тодорхойлж экосистемийн үйлчилгээний (цэвэр ус, агаар, хоол хүнс гэх мэт) жишээ нэрлэх; b. Экосистемийн амьтай ба амьгүй бүрэлдэхүүнийг нэрлэх (амьтан, ургамал, агаар, ус, нар, хөрс гэх мэт); c. Орон нутгийн түвшинд экосистемийн хомсдол үүсэх эсэх тухай жишээ хэлэх (мод огтлох → шувуудын тоо толгой буурах → хөнөөлт шавж, мэрэгч амьтдын тоо ихсэх гэх мэт); d. Экосистемд мал яаж нөлөөлөх тухай ярилцаж эерэг, сөрөг жишээ гаргах.
	1.1.3 Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөн дэх экосистем	<ul style="list-style-type: none"> a. Уур амьсгалын өөрчлөлт экосистем болон байгалийн нөөцөд яаж нөлөөлж байгааг тайлбарлах (орон нутгийн жишээн дээр); b. Монгол Улс уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэж байгаа талаар болон та хэрхэн оролцож байгаа тухай жишээ хэлэх¹¹; c. Мал аж ахуйн бүтээгдэхүүний харьцангуй давуу талуудыг орон нутгийн жишээгээр тайлбарлах (бэлчээрийн мал аж ахуй нь бусад суурин хэлбэрийн мал аж ахуйг бодвол байгаль, уур амьсгал нөхцөлд дасан зохицох чадвар сайтай гэх мэт).
	1.1.4 Биологийн олон янз байдал	<ul style="list-style-type: none"> a. Биологийн олон янз байдлыг тодорхойлох, яагаад малчид мэдэж ойлгож байх хэрэгтэй талаар тайлбарлах; b. Мал аж ахуйн биологийн олон янз байдал болон холбогдох экосистемийн үйлчилгээнд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөг тодорхойлох, жишээ хэлэх (хөрсний бүрдэл, шимт бодисын агууламж эргэлт).

¹¹ <https://www.greenclimate.fund/sites/default/files/document/mongolia-country-programme.pdf>

1

Байгалийн нөөц ашиглах

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
1.2 Ус	1.2.1 Усны эргэлт	a. Усны эргэлтийн гол төлөвүүдийг нэрлэх (ууршилт, конденсац, хур тунадас, ус цуглуулалт); b. Газрын гадаргад усны оршин байх 3 хэлбэрийг хэлэх (гадаргын урсац, нэвчилт, ууршилт гэх мэт); c. Хур тунадас, ууршилт нь мал аж ахуйд хэрхэн нөлөөлөхийг тайлбарлах.
	1.2.2 Ус ашиглалтын менежмент	a. Үер (үер, элэгдэл, бохирдол) ба усны хомсдолын (ган) үр дагаврыг тайлбарлах; b. Орон нутгийн түвшинд усыг илүү үр ашигтай ашиглах боломж байгааг тодорхойлох (ус хуримтлуулах, хөв цөөрөм, мод, эрүүл хөрс гэх мэт); c. Голын эх болон адгийн хэрэглэгчид ус ашиглалтыг хэрхэн тэгш хэм хэмжээтэй хэрэглэх талаар жишээ гаргах.
1.3 Хөрс		a. Хөрсний төрлүүдийг тодорхойлж (элс, шороо, шавар, чулуулаг) тэдгээрийн онцлогийг дурдах; b. Хөрсний элэгдэл үүсэх шалтгааныг нэрлэх (цаг агаар, гулгалт, бүрхэвч, хэт ашиглалт); c. Өнгөн хөрсийг хэмжих, үр дүнг тайлбарлаж ярилцах; d. Мал аж ахуй хөрсөнд үзүүлэх эерэг, сөрөг нөлөөг нэрлэх (бэлчээрлэлт, идээшлэх, малын төрлөөр, бэлчээрийн даац, өтөг бууцны менежмент); e. Орон нутгийн түвшинд хөрсний тогтвортой менежментийн талаарх ярилцах; f. Хөрсний органик бодисын ашиглалтыг сайжруулах жишээ боловсруулах (ургамлын бүрхэвч, хөрсийг хучих).
1.4 Бэлчээр		a. Бэлчээрийн мал аж ахуй болон эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийн түүхийг товч тайлбарлах; b. Бэлчээрийн үнэлгээнд хэрэглэж болох шалгуурыг нэрлэх (хөрсний төрөл, ургац, биологийн олон янз байдал, морфологи, ус, хортон шавж); c. Танай нутгийн болон Монголын ¹² бэлчээрийн төлөв байдлын талаар саналаа солилцох; d. Бэлчээрийн доройтлыг бууруулах шийдвэрийг ярилцах.
1.5 Бусад нөөц	1.5.1 Зэрлэг амьтад	a. Зэрлэг амьтдыг хамгаалах нь экосистемийн хувьд чухал болохыг тайлбарлах; b. Зэрлэг амьтад, малын хоорондын харилцан уялдааг харуулах жишээ хэлэх (бэлчээрийн давхцал, махчин амьтад сул дорой малыг идэх гэх мэт).

¹² https://www.eda.admin.ch/dam/countries/countries-content/mongolia/en/Mongolia-Rangeland-health-Report_EN.pdf

1



Байгалийн нөөц ашиглах

1.5 Бусад нөөц

1.5.2 Ой

- a. Ой бүхий газрын экосистемд үзүүлэх үүргийг тайлбарлах.
- b. Мал бэлчээрлэлтэд ойн ач холбогдлыг нэрлэх (бут сөөг, нүүрсхүчлийн хийн шингээлт, силвапасторализм¹³);
- c. Танай нутагт байгаа ойг тогтвортой ашиглах, нөхөн сэргээх талаар ярилцах.

1.6 Шимт бодис

- a. Экосистемд шимт бодисын эргэлтийн ач холбогдлыг нэрлэх (ус, нүүрс-ус, азот гэх мэт);
- b. Шимт бодисын эргэлтийн ач холбогдлыг өөрийн нутгийн жишээгээр тайлбарлах (мал, амьтан, ургамал, хүнс/тэжээл, өтөг бууц зэргийн хамаарлыг бодолцон.)

1.7 Нөөцийн хомсдол

- a. Нөөцийн хомсдолын жишээнүүдийг нэрлэх (газрын гүний усны хомсдол, ойн хомсдол, эрсдэлийн хомсдол, бохирдол, шатаах зэрэг хөдөө аж ахуйн практик ажиллагаа, хөрсний элэгдэл гэх мэт);
- b. Хөрсний хомсдолын шинж тэмдэг, эрсдэлийг нэрлэх (хөрс хуурах, ургамлын үндэс цухуйх, гуу жалга үүсэх, хүчтэй үерийн ул мөр гэх мэт);
- c. Хөрсний хомсдолыг орон нутгийн түвшинд шийдэх арга замуудын талаар ярилцах.

¹³ <http://www.fao.org/3/ca2792en/ca2792en.pdf>



ЧАДАМЖ 2

БЭЛЧЭЭР АШИГЛАХ

Мал бэлчээрлэлтийн менежмент, бэлчээр ашиглалт, хамгаалалт, сайжруулалт зэрэг бэлчээрийн ашиглалтын мэдлэг, чадвар, чадамж эзэмшүүлнэ.

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
2.1 Зарчим	2.1.1 Ургамалжилт	a. Бэлчээрт зонхилох ургамлыг нэрлэх; b. Ургамлын нөмрөгийн (биологийн олон янз байдал) үнэ цэнийг тайлбарлах; c. Танай нутагт ургадаг малын тэжээлийн ач холбогдолтой болон ач холбогдол багатай ургамлыг тодорхойлох; d. Ургамлын олон янз байдлыг нэмэгдүүлдэг бэлчээрийн менежментийн жишээ гаргах.
	2.1.2 Ургамлын өсөлт, хөгжилт	a. Ургамлын өсөлт, хөгжлийн үе шатыг тодорхойлох; b. Малын идэх дуртай ургамлын зүйлийг малын төрлөөр тодорхойлох (идэмж гэх мэт), ургамлын өсөлтөд малын үзүүлэх нөлөөг тогтоох.
2.2 Бэлчээр сайжруулалт	2.2.1 Менежментээр сайжруулах	a. Бэлчээр ашиглалтын уламжлалт болон одоогийн хэрэгжүүлж буй арга барилыг харьцуулан ярилцах; b. Сайн бэлчээрийн менежментийн голлох хүчин зүйлийг нэрлэх (малын тэжээлийн хангамж, бэлчээрийн ачаалал, бэлчээрлэх хугацаа, бэлчээр амрааж өнжөөх гэх мэт). c. Бэлчээрийн даац гэж юу болохыг тодорхойлж, тодорхой жишээн дээр тооцоолох (хонин толгойгоор); d. Бэлчээрийн сэлгээг тодорхойлон хэлж бэлчээрт болон малд үзүүлэх үр өгөөжийг тайлбарлах; e. Малын бэлчээрлэлтийн зан араншны ялгааг төрөл тус бүрээр тодорхойлж, жишээгээр тайлбарлах (бэлчээрлэлтийн давтамж, бэлчээрлэх талбай, идээшлэл гэх мэт); f. Малын тэжээлийн физиологийн ерөнхий хэрэгцээг төрөл бүрээр тайлбарлах; g. Бэлчээрийг сэлгэж ашиглах боломжийг орон нутгийнхаа жишээн дээр ярилцаж төсөөлөл гаргах; h. Байгаль, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн менежментийн талаар ярилцах; i. Бэлчээрийн талхагдлын гол үр дагаврыг нэрлэх (элэгдэл, хөрс, биологийн олон янз байдлын хомсдол);

2



Бэлчээр ашиглах

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
2.2 Бэлчээр сайжруулалт	2.2.1 Менежментээр сайжруулах	j. Бэлчээрийн менежментийн эерэг, сөрөг жишээнүүдийг ярилцах (бэлчээрийн даац хэтрэлт, бэлчээрийн ургамлын ургац, мал бэлчээрлэлт хоорондын зохисгүй харьцаа, өтөг бууцны хэмжээ).
2.3 Бэлчээр хамгаалал	2.3.1 Зарчим	a. Бэлчээр хамгаалал ¹⁴ гэдгийг тодорхойлон уламжлалт бэлчээрийн менежментээс ямар ялгаатай болохыг жишээгээр тайлбарлах (хяналт үнэлгээ хийх, малын төрлийг сонгон бэлчээх гэх мэт); b. 5 хошуу малын бэлчээрлэлтийн ялгааг үнэлж тэдний бэлчээр хамгаалал, нөхөн сэргээлтэд хэрхэн нөлөөлдөг тухай ярилцах; c. Орон нутгийн түвшинд бэлчээр хамгаалал, нөхөн сэргээлтийн ямар арга хэрэглэдэг талаар ярилцах.
	2.3.2 Бэлчээр сайжруулалт	a. Отрын нөөц бэлчээрийн ач холбогдлыг тайлбарлах; b. Бэлчээр сайжруулах уламжлалт аргын талаар ярилцах; c. Бэлчээр сайжруулах аргуудын үр өгөөжийг хэмжих шалгуурыг сонгох.
	2.3.3 Бэлчээр амраах/отрын бэлчээр	a. Отрын бэлчээр яагаад шаардлагатай болохыг тайлбарлах; b. Өвөл хаврын улирлын бэлчээрийг хэрхэн амрааж ашиглах зохицуулалттай байгааг тайлбарлах .
	2.3.4 Бэлчээрийн төлөв байдал/эрүүл мэнд	a. Яагаад бэлчээрийг эрүүл соргог байлгах шаардлагатай болохыг тайлбарлах (ашиглалт бусад ачааллыг бууруулах гэх мэт); b. Бэлчээрийн төлөв байдлыг сайжруулах аргуудыг нэрлэх (сэлгээ, төрөл бүрийн мал бэлчээх, өтөг бууцнаас чөлөөлөх); c. Танай нутаг бэлчээрийг соргог байлгах ямар менежмент хэрэгжүүлэх тухай ярилцах (бэлчээр ашиглагчдын хэсэг, бүлэг нөхөрлөл, хоршоо, гэх мэт).
2.4 Тогтолцоо		a. Одоогийн хэрэгжүүлж буй бэлчээрийн менежментийг НҮБ-ээс гаргасан удирдамж, гарын авлага материалд тусгагдсантай харьцуулах (Бэлчээрийн газар ашиглалтын засаглалын сайн дурын зөвлөмж ¹⁵); b. Өнөөгийн бэлчээр ашиглалтын эрхзүйн зохицуулалтыг тогтвортой хөгжлийн зарчим талаас харж үнэлгээ өгөх (нүүдэл, малын шилжилтийг хязгаарлах нь бэлчээрийн талхагдал, малчдын хоорондын маргаан зөрчлийг нэмэгдүүлэх эрсдэлтэй гэх мэт).

¹⁴ Бэлчээр хамгааллын ижил утгатай үг бол "зорилтот бэлчээр" гэсэн нэр томъёо бөгөөд энэхүү гарын авлагад оруулсан байна.: <https://www.webpages.uidaho.edu/rx-grazing/Handbook/ASITargetGrazingBook2006.pdf>

¹⁵ <http://www.fao.org/3/i2801e/i2801e.pdf>

2



Бэлчээр ашиглах

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
2.4	Тогтолцоо	с. Бэлчээр ашиглалт, хамгаалалтын эрх зүйн зохицуулалтыг хэрхэн сайжруулах талаар ярилцах (сум, багийн болон улс аймгийн түвшинд).
2.5	Тэжээл бэлтгэл	а. Тэжээлийг хэрхэн бэлтгэж, зөв хадгалах тухай тайлбарлах (хадлан, дарш гэх мэт); b. Малын тэжээл бэлтгэж, нөөцлөхийн ач холбогдлын талаар ярилцах.
2.6	Бусад нэмэлт тэжээл бэлтгэл	а. Малын тэжээлийн зориулалтаар тариалж болох ургамлыг нэрлэх (царгас, арвай, овьёос, эрдэнэшиш гэх мэт); b. Малын тэжээлийн таримал ургамлын олдоц, хэрэглээний талаар ярилцах.



ЧАДАМЖ 3

МАЛ МАЛЛАХ

Мал сүргийг эрүүл байлгах, үржүүлэг, тэжээллэгийг зохицуулан тавлаг байдлыг хангах мэдлэг, чадвар, чадамжийг эзэмшүүлэх.

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
3.1 Мал аж ахуй	3.1.1 Зарчим	<ul style="list-style-type: none"> a. Мал амьтдын энгийн хэрэгцээг нэрлэх (цэвэр дулаан хашаа, хороо, тэжээл, ижил сүрэг гэх мэт); b. Мал амьтны хэвийн зан араншныг хэвийн бус араншнаас ялгаж харж сурах, түүнийг яаж хэвийн болгох тухай ярих; c. Мал аж ахуй эрхлэлтийн хэлбэрүүдийг нэрлэж жишээ гаргах, түүний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн (мах, сүү, арьс шир, ноос ноолуур, уналга, ачлага гэх мэт) талаар ярилцах.
3.2 Мал амьтны эрүүл мэнд	3.2.1 Зарчим	<ul style="list-style-type: none"> a. Мал амьтны физиологийн /биеийн/ байдлыг үнэлэх (бие галбарын үнэлгээгээр); b. Өвчтэй малыг эрүүл малаас хэрхэн ялгаж танихыг тодорхойлох.
	3.2.2 Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх	<p>Малыг өвчнөөс сэргийлэх арга замуудаас нэрлэх (эрүүл ахуй, хашаа хороо, өвчтэй малыг тусгаарлах, вакцин хийлгэх, халдваргүйжүүлэх болон бусад эмчилгээ).</p>
	3.2.3 Түгээмэл тохиолдох малын өвчин	<ul style="list-style-type: none"> a. Түгээмэл тохиолдох малын өвчнийг жагсаан бичих (шүлхий, мялзан, Бруцеллёз гэх мэт); b. Танай нутагт гардаг малын нэг өвчин сонгоод түүний шинж тэмдэг, оношилгоо, эмчилгээний талаар товч тодорхойлох.
	3.2.4 Зооноз өвчин	<ul style="list-style-type: none"> a. Малаас хүнд, хүнээс малд халдварлах /зооноз/ өвчнийг тодорхойлон жишээ гаргах; b. Зооноз өвчний тархалтын тойргийг оролцогч хүчин зүйлсийн хамтаар тайлбарлах (зэрлэг амьтад, шавж, шимэгч хорхой, хүнс гэх мэт); c. Зооноз өвчний хүн, малд илрэх сэжигтэй шинж тэмдгүүдийг нэрлэх (Бруцеллёз гэх мэт); d. Зооноз өвчний дэгдэлтийн үеийн авах арга хэмжээ, тайлагналтын талаар ярилцах.
	3.2.5 Багаж төхөөрөмж	<ul style="list-style-type: none"> a. Малын эрүүл мэндийг сахин хамгаалах стандарт /энгийн/ багаж төхөөрөмжийг нэрлэх (халууны шил, хөхний үрэвсэл хэмжигч, хашаа хороо, халдваргүйжүүлэх/ариутгах материал, хөнгөлөх бөгж/багаж, хавчуур хямсаа, шөвөг гэх мэт); b. Багажийг сонгож хэзээ, яаж хэрэглэдэг тухай тайлбарлах.

3



Мал маллах

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
3.2 Малын эрүүл мэнд	3.2.6 Малын эмийн зохистой хэрэглээ	<p>a. Ямар тохиолдолд ямар төрлийн эм өгөх тухай жишээ хэлэх;</p> <p>b. Малын эмийг зохисгүй хэрэглэх тохиолдлыг тодорхойлон хэлэх;</p> <p>c. Малын эмийн зохисгүй хэрэглээнээс үүдэх эрсдэлийг тайлбарлах (халдвар, бэрхшээлийн зэргийг нэмэгдүүлэх, дур мэдэн эм хэрэглэх эсвэл хууль бус эм худалдан авахын хуулийн хариуцлага, нян тэсвэрлэлт, бүтээгдэхүүн дэх нянгийн үлдэг гэх мэт);</p> <p>d. Малын эмийн зохистой хэрэглээг зохицуулах эрхзүйн зохицуулалт, удирдамж, зааврын талаар ярилцах.</p>
	3.2.7 Нянгийн эсрэг эсэргүүцэл	<p>Чадамж 9 -ийг үзнэ үү.</p>
	3.2.8 Мал эмнэлгийн үйлчилгээ, эрх зүйн зохицуулалт	<p>a. Орон нутаг дах мал эмнэлгийн үйлчилгээний системийг тодорхойлон хэлэх (мал эмнэлгийн үйлчилгээ, дүрэм журам, товллолд вакцинжуулалт гэх мэт);</p> <p>b. Тохиолдол ихтэй, заавал төрийн захиргааны байгууллагад мэдэгдэх шаардлагатай өвчнүүдийг нэрлэн, захиргааны байгууллагад заавал мэдэгдэхийн ач холбогдлыг тайлбарлах;</p> <p>c. Сүм¹⁶ хооронд болон сум дотор малын шилжилт хөдөлгөөн хийх, эрүүл мэндийг хамгаалах, тавлаг байдлыг хангахад чиглэгдсэн бусад зохицуулалтыг нэрлэх (мал амьтны эрүүл мэндийн тухай гэх мэт);</p> <p>d. Малын эрүүл мэндийг хамгаалах системийн ач холбогдлыг орон нутгийн түвшинд авч үзэн харилцан ярилцах (малын халдварт өвчин, (жишээ нь хил дамнасан малын өвчин, хоол хүнсээр дамжих өвчин, хүнсний эрүүл ахуй, шинээр гарч буй өвчин).</p>
	3.2.9 Малын тавлаг байдал	<p>a. Малын тавлаг байдал гэж юу болохыг тодорхойлох (дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт);</p> <p>b. Тавлаг байдал нь хангагдахгүй байгаа малын шинж тэмдгийг нэрлэх (ачлага, уналгын нөхцөл, байнгын уяатай байх, тэжээл дутсан гэх мэт);</p> <p>c. Тавлаг байдал нь хангахгүй байхын үр дагаврыг нэрлэх (жишээ нь хэвийн бус зан авир гаргах, үржлийн чанар муудах, сувайрах, тэжээл, усанд дүргүй болох);</p> <p>d. Малын тавлаг байдал яагаад чухал болохыг тайлбарлах (ашиг шим, бүтээгдэхүүн үйлдвэрлэж хэрэгцээ хангах, малтай зохистой харьцах гэх мэт);</p>

¹⁶Сум нь Монгол Улсын засаг захиргааны хоёрдох жижиг нэгж (англи хэлний дүүрэг гэх үгтэй жишиж ойлгож болно).

3



Мал маллах

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
3.2 Малын эрүүл мэнд	3.2.9 Малын тавлаг байдал	e. Танай нутагт малын тавлаг байдлыг хэрхэн хангах/сайжруулж болох талаар харилцаан ярилцах).
	3.2.10 Био-аюулгүй байдал	a. Био-аюулгүй байдал гэж юу болох, яагаад малчдын хувьд чухал болохыг тайлбарлах; b. Танай нутаг био-аюулгүйн байдлын нөхцөл ямар байгааг дүрслэх (хил гаалиар нэвтрүүлсэн шинэ төрлийн тэжээл/долооц, мал амьтныг ашиглах, бусад төрлийн гаднын биет); c. Био-аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах жишээ нэрлэх (Шинээр авчирсан болон өвчтэй малыг тусгаарлах, вакцин хийлгэх, зэрлэг амьтадтай харьцахаас сэргийлэх, өвчлөлийг мэдэгдэх, зэг зэмийг устгах гэх мэт).
3.3 Мал үржүүлэг		a. Малын үржүүлгийн зорилгыг тайлбарлах; b. Үржлийн мал сонгох шалгуур үзүүлэлтийг нэрлэх (эрүүл мэнд, төлөрхөг чанар, сүүний гарц, орон нутгийн байгаль, цаг уурт дасан зохицсон байдал гэх мэт); c. Хоёр төрлийн үржлийн мал сонгоод хүснэгтлэн харьцуулж үзээд таны сүрэгт болон таны зорилтот аль нь илүү тохирохыг сонгох; d. Эрлийжүүлгийн аргуудаас жишээ дурдах; e. ХХААХҮЯ-ны ¹⁷ сайдын баталсан таван төрлийн малын үржлийн стратегийг товч дүрслэн өгүүлэх; f. Малчдын бүлэгт тулгуурласан мал үржлийн хөтөлбөр/арга барилыг танай нутагт хэрэгжүүлэх боломжийн талаар харилцан ярилцах (төвлөрсөн байдлаар хэрэгжүүлэх үржлийн ажлын схемтэй харьцуулсан байдлаар); g. Бог мал болон үхэр сүргийн цөм сүрэг бий болгож эцэг малыг тусад нь ялган төвлөрүүлэх; h. Гарал үүсэл нь өөр байх нь нэг гаралтай малаас илүү чанартай болохыг тайлбарлах (цаг уурын болон өвчний тохиолдол болон нийгэм соёлын хөгжилд дасан зохицох боломж гэх мэт); i. Зохиомол хээлтүүлгийн давуу болон сул талыг харьцуулах.
3.4 Тэжээллэг		a. Танай нутагт олдоцтой малын тэжээлийг нэрлэх (хадлан, гар тэжээл болон таримал тэжээлийн ургамал); b. Малын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үе шатад тохируулан төрлийн ялгаатайгаар тэжээх тохиромжтой тэжээлийг сонгох (хээлтэй, өсөлт хөгжилт гэх мэт); c. Малыг эрдэст тэжээлээр хангахын ач холбогдлыг тайлбарлах; d. Мал амьтад эрдсийн хэрэгцээгээ хэрхэн нөхдөг талаар жишээ гаргах (байгалийн нөөцөөр болон нэмэлтээр гэх мэт).

¹⁷ Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам <https://mofa.gov.mn/exp/>

3



Мал маллах

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
3.4 Тэжээллэг		e. Тэжээлийн хувьд хивэгч малын харьцангуй давуу талыг тодорхойлон ярилцах (хивэгчид, ургамлын материалыг идэх боломжтой хүнс болгон хувиргах гэдэсний бичил биетнүүд гэх мэт).
3.5 Сүргийн менежмент		a. Мал бэлчээрлэлтийн менежментийн зарчмуудыг чадамж 2 -аас харна уу; b. Сүргийн эргэлтийн хөдлөл зүйг тодорхойлох хэмжүүрийг нэрлэх (нөхөн бүрдүүлэлтийн хувь, төлөлт, хорогдол гэх мэт); c. Урт хугацаанд ашигтай байх сүргийг бий болгох талаар харилцан ярилцах (сүргийг өнөөгийн нөхцөлд дасан зохицуулах, жишээ нь ямаан сүрэг богино хугацаанд нөхөн үржиж байхад тэмээ харьцангуй удаан байх).
3.6 Мал аж ахуйн үйлчилгээ	3.6.1 Малд зориулсан үйлчилгээнүүд	a. Танай нутагт байгаа мал аж ахуйн үйлчилгээний жишээ гарган ярилцах; b. Сүргийн чанар сайжруулахуйц нэг үйлчилгээг сонгох.
3.7 Малд зориулсан багаж төхөөрөмж, хашаа хороо	3.7.1 Нийтлэг туршлага	d. Малын төрөл тус бүрийг хэрхэн барьж номхруулах тухай тайлбарлах. e. Түгээмэл хэрэглэгддэг нэг аргыг сонгоод хэрхэн яаж зөв хийдэг тухайгаа тайлбарлах (хөнгөлөх, тэмдэглэх, сургах/номхруулах, барих, төллүүлэх, эмчлэх, эвэр, туурайг засах гэх мэт); f. Малтай зөв харьцах болон ашиг шим үйлдвэрлэлтийн хооронд харилцан хамаарлыг тайлбарлах (стрессийн хүчин зүйлийг бууруулах, тавлаг байдлыг хангах, аюулгүй байдлыг хангах, махны чанар гэх мэт); g. Малтай зөв харьцаж, стрессийн хүчин зүйлийг бууруулах өөрсдийн туршлагын талаар харилцан ярилцах.
	3.7.2 хашаа хороо	a. Малыг дулаан хэвтэр /хашаа/-тэй байлгахын ач холбогдлыг тайлбарлах; b. Төрөл бүрийн малд зориулсан хашаа хороо (хэмжээ, өндөр, температур, гэрэлтүүлэг гэх мэт); c. Зөөврийн хашаа түүний орон нутгийн нөхцөлд үзүүлэх өгөөжийг талаар харилцан ярилцах.



ЧАДАМЖ 4

МАЛЫН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОВСРУУЛАХ

Мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн (хүнс болон түүхий эд)-ийг бэлтгэх, боловсруулах, хадгалах болон бусад шат дамжлагууд, холбогдох стандартуудын талаарх мэдлэг, чадвар, чадамж эзэмшүүлэх.

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
4.1 Мал төхөөрч бэлтгэх		<ul style="list-style-type: none"> a. Малыг хэрхэн төхөөрч бэлтгэдэг тухайгаа дүрслэн үзүүлэх; b. Малыг хүнсний болон зориулалтаар төхөөрч болохгүй үеийг нэрлэх (эмийн шимэгдэх үе дотор, өвчний шинж тэмдэг илэрсэн үе гэх мэт); c. Малын бүтээгдэхүүний чанарт сөргөөр нөлөөлж болох төхөөрөхөөс өмнөх болон дараах нөхцөлүүдийг нэрлэж жишээгээр тайлбарлах; d. Орон нутгийн нөхцөлд өлгүүр/дүүжлүүр ашиглан мал төхөөрөх боломжийг ярилцаж үнэлгээ өгөх.
4.2 Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах	4.2.1 Мах, махан бүтээгдэхүүн	<ul style="list-style-type: none"> a. Орон нутгийн түвшинд мах боловсруулах үйл явцыг дүрслэн үзүүлэх; b. Орон нутгийн чанартай аргаар мах боловсруулахын танд болон мах хэрэглэгчийн эрүүл мэндэд үзүүлж болох эрсдэлийг жагсаах; c. Орон нутгийн түвшинд мах боловсруулалтыг хэрхэн сайжруулах талаар харилцан ярилцах.
	4.2.2 Сүү, сүүн бүтээгдэхүүн	<ul style="list-style-type: none"> a. Орон нутагт түгээмэл хэрэглэгддэг сүү цуглуулж боловсруулах аргуудыг дүрслэн ярих; b. Сүүг цэвэр байлгах, аюулгүй байдлыг хангахын ач холбогдлыг нэрлэх; c. Орон нутгийн хэмжээнд шинэ төрлийн сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийн талаар харилцан ярилцах (бяслаг, тараг); d. Сумын түвшинд шинэ төрлийн сүүн бүтээгдэхүүн боловсруулах технологийн боломжийг үнэлэх; e. Арилжаалагдах чадвартай сүүн бүтээгдэхүүний гэрийн нөхцөлд үйлдвэрлэх жишээ гаргах, ярилцах (хэрэглэгчдийн эрэлт, сонирхлыг анхаарч үзэх).
	4.2.3 Ноос, ноолуур	<ul style="list-style-type: none"> a. Ноос хайчлах, ноолуур самнах түгээмэл аргуудыг дүрслэн ярилцаж тэдгээрийн давуу болон сул талуудыг үнэлэх;

4		Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах	
СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	
4.2 Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах	4.2.3 Ноос, ноолуур	b. Ноос авах уламжлалт болон орчин цагийн техникүүдийг ¹⁸ тайлбарлах; c. Ноос хайчлах, ноолуур самнах шинэлэг техник, багажийг туршиж үзэх /боломжтой бол/; d. Ноос, ноолуур, хөөврийг ангилах, савлах, чанарыг зэрэг тогтоох аргуудаас жишээ болгон ярилцах; e. Ангилж ялгаж савлах нь яагаад ач холбогдолтой болохыг тайлбарлах.	
	4.2.4 Арьс, шир болон бусад түүхий эд, бүтээгдэхүүн	a. Мал өвчих түгээмэл аргуудыг тодорхойлон тэдгээрийн давуу болон сул талуудыг үнэлэх; b. Мал өвчилтийг сайжруулах аргуудаас жишээ дурдах (өлгүүр/дүүжлүүр ашиглах, зориулалтын хутга хэрэглэх гэх мэт); c. Арьс, ширийг боловсруулалтад бэлтгэх, анхан шатанд тордох; d. Арьс, шир болон яс, эвэр зэрэг бусад түүхий эдийн ашиглалтыг сайжруулах талаар харилцан ярилцах (арьсан бүтээгдэхүүн, эмээл, хязгаар хийх, бордоо болгох гэх мэт).	
4.3 Хүнсний чанар, аюулгүй байдал	4.3.1 Зарчим	a. Хүнсний чанар аюулгүй байдал гэж юу болохыг тодорхойлох; b. Мах, сүүн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын шаардлагуудыг мэддэг болох; c. Хүнсний аюулгүй байдлын шаардлага хангахгүй бэлтгэлийн аргууд болон түүгээр дамжих өвчний талаар жишээ гарган ярилцах; d. Хүнс бэлтгэлийг чанартай болгох энгийн хэмжүүрүүдийг нэрлэх (ариун цэвэр сахиулах, түүхий болон боловсруулан бүтээгдэхүүнийг тусад нь байлгах, хүнсний бүтээгдэхүүнийг зохих температурт хадгалах, цэвэр аюулгүйн шаардлага хангасан ус болон бусад материал ¹⁹ ашиглах гэх мэт).	
	4.3.2 Хүнсний бүтээгдэхүүний савлагаа	a. Хүнсний бүтээгдэхүүнийг хэрхэн ангилж, савлах тухай ярих; b. Худалдаалах бүтээгдэхүүнийг хэрхэн ангилж, савлаж хадгалах боломжит арга замыг нэрлэх.	
	4.3.3 Мөшгөх систем	a. Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний мөшгөх системийг тодорхойлон хэлэх; b. Мөшгөх системийн ач холбогдлын талаар харилцан ярилцах.	
	4.3.4 Эрхзүйн орчин	Хүнсний үйлдвэрлэл эрхлэлттэй холбоотой стандарт болон бусад эрх зүйн зохицуулалтын баримт бичгүүдийг жагсаан нэрлэх (үйлдвэрлэгч, боловсруулагч нарыг оролцуулаад ²⁰).	

¹⁸ <https://learning.rdili.edu.mn/>

¹⁹ <https://www.who.int/publications/i/item/9789241594639>

²⁰ Үүнд үндэсний, бүс нутгийн болон олон улсын лавлагааг багтааж болно (жишээлбэл, худалдааны гэрээ, кодекс гэх мэт).

4



Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
4.4 Хог хаягдлын менежмент		<ul style="list-style-type: none"> a. Малын гаралтай хог хаягдлыг нэрлэх (сэг зэм, өтөг бууц, өөх тос, арьс шир, ашигласан ус, агаар, эмийн үлдэгдэл гэх мэт); b. Малын сэг зэмийг яагаад зохих ёсоор устгах шаардлагатай талаар тайлбарлах; c. Мал төхөөрөх, арьс боловсруулах, сүүн бүтээгдэхүүн боловсруулалт²¹ зэргээс гарсан бохир усыг устгах, хоргүйжүүлэх талаар тодорхойлох; d. Малын гаралтай хог хаягдлаас үүдэлтэй танай нутагт үүсэж байгаа сөрөг нөлөөллийн жишээ нэрлэх (ашиглалтгүй өтөг бууц, гол горхи, нуур цөөрмийн усны бохирдол гэх мэт); e. Танай нутагт тохирохуйц хог хаягдлын менежментийг сонгож түүний хэрэгжүүлэх боломжийн талаарх харилцан ярилцах; f. Байгаль орчинд ээлтэй бие засах газар барих талаар харилцан ярилцах; g. Ашиглалтгүй өтөг бууцны байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж түүнийг тогтвортой ашиглах жишээ гаргах (ашиглалтыг сайжруулах, бордоо болгох, түлшинд хэрэглэх, биохийн бүтээгдэхүүн болгох гэх мэт).

²¹ <http://www.fao.org/3/X6114E/x6114e03.htm#b5-1.2.1.%20Wastewater>



ЧАДАМЖ 5

ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ, АРГА БАРИЛ АШИГЛАХ

Мал аж ахуйн салбарт дижитал хэрэгсэл, боловсролын үйлчилгээ зэрэг менежментийн шинэлэг технологи, арга барил ашиглах мэдлэг, чадвар, чадамж эзэмшүүлэх.

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
5.1 Зарчим		<ul style="list-style-type: none"> a. Инновац гэж юу болох яагаад чухал болохыг тайлбарлах; b. Бэлчээрийн мал аж ахуйд хэрэглэж болох инновацын талаар жишээ гаргаж ярилцах (технологийн талаар боловч нийгэм, эдийн засгийн бусад нөлөөллийг хамтад үзэх); c. Инновацын бүтээгдэхүүнд тулгарч байгаа хүндрэл бэрхшээл болон түүнийг орон нутагт хэрэгжүүлэх нөөц, боломжийн талаар харилцан ярилцах.
5.2 Арга замууд /арга хэрэгсэл/	5.2.1 Уур амьсгалд зохицсон ухаалагч хөдөө аж ахуй	<ul style="list-style-type: none"> a. Уур амьсгалд зохицсон ухаалагч хөдөө аж ахуй гэж юу болохыг тодорхойлох²²; b. Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй²³ аж ахуйг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх өөрийн саналаа илэрхийлэх.
	5.2.2 Нүүрсхүчлийн ялгарал багатай мал аж ахуй	<ul style="list-style-type: none"> a. Нүүрсхүчлийн ялгарал багатай мал аж ахуй²⁴ гэж юу вэ? Яагаад чухал болохыг тайлбарлах; b. Мал аж ахуйгаас ялгарах 3 төрлийн хүлэмжийн хийг нэрлэх; c. Орон нутгийн түвшинд нүүрсхүчлийн ялгарлыг бууруулах үйл ажиллагааны талаар ярилцаж жишээ гаргах (малын тэжээл ашиглалтыг нэмэгдүүлэх, бэлчээр сэлгэж ашиглан ургамалжилтыг нэмэгдүүлэх, бэлчээрийн ачааллыг зохицуулах, дагалдах бүтээгдэхүүнийг хөгжүүлэх гэх мэт).
	5.2.3 Цахим хөдөө аж ахуй	<ul style="list-style-type: none"> a. Мэдээлэл, технологийн хэрэглээг тодорхойлох; b. Цахим хөдөө аж ахуйн²⁵ хүрээнд мэдээлэл технологийн оруулах үр өгөөжийг тайлбарлах; c. Танай нутагт цахим хөдөө аж ахуйтай холбоотой гэж хэлж болохуйц үйл ажиллагаа байгаа эсэх эсвэл хэрэгжүүлэх болох санаа байвал хэлэх (байрзүйн төхөөрөмж хэрэглэх, зайнаас тандах үйлчилгээ, гар утсаараа мэдээлэл авах, үүлэн технологи гэх мэт).

²² <http://www.fao.org/3/a-i4226e.pdf> <https://www.adb.org/sites/default/files/publication/31145/making-grasslands-sustainable-mongolia.pdf>

²³ Уур амьсгалын өөрчлөлтийн талаархи FAO-ийн цахим сургалт: <http://www.fao.org/climatechange/67624/en/>

²⁴ <http://www.fao.org/3/ca7089en/ca7089en.pdf>

²⁵ <http://www.fao.org/3/a-i6909e.pdf>; <http://www.fao.org/3/ca4985en/ca4985en.pdf>

5



Дэвшилтэт технологи, арга барил ашиглах

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
5.2 Арга замууд /арга хэрэгсэл/	5.2.3 Цахим хөдөө аж ахуй	d. Цахим хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд анхаарах зүйлсийг тодруулах бие даасан байдал, аюулгүйн байдал, дата хангамж, ажиллах хүчийг орлуулах, дижитал); e. Нутагтаа цахим хөдөө аж ахуй хөгжүүлэх талаар ярилцах; f. Мал аж ахуйн тоног төхөөрөмж, дижитал багаж хэрэгслийн тухай (байршил тогтоогчтой хүзүүвч гэх мэт).
	5.2.4 Хөдөө аж ахуйн зохистой дадал	Хөдөө аж ахуйн зохистой дадал ²⁶ гэж юу болохыг тодорхойлж орон нутагт байгаа талаар жишээ гаргах.
	5.2.5 Тэжээллэг чанартай хүнс үйлдвэрлэлд суурилсан хөдөө аж ахуй	a. Тэжээллэг чанартай хүнс үйлдвэрлэлд суурилсан хөдөө аж ахуй ²⁷ -ийг тодорхойлох; b. Тэжээллэг чанартай хүнс үйлдвэрлэлд суурилсан хөдөө аж ахуйг жишээгээр тайлбарлах (өлсгөлөн, шим тэжээлийн дутагдал, чихрийн шижин зэрэг хооллолтоос үүдэлтэй өвчин гэх мэт); c. Орон нутгийн түвшинд хөдөө аж ахуй, хүнс үйлдвэрлэлийн системийг хэрхэн тэжээллэг чанарт суурилсан хүнс үйлдвэрлэл болгон хөгжүүлэх талаар харилцан ярилцах.
	5.2.6 Органик хөдөө аж ахуй	Органик хөдөө аж ахуйн суурь зарчмуудыг нэрлэж тодорхойлох (эрүүл мэнд, экологи, тэгш байдал).
	5.2.7 Сэргээгдэх эрчим хүч	a. Сэргээгдэх эрчим хүчний ²⁸ эх үүсвэр гэж юу болохыг тодорхойлон яагаад чухал болохыг тайлбарлах; b. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг орон нутагт хэрэгжүүлэх болон хэрэгжүүлж байгаа талаар жишээ гаргах, тайлбарлах.
	5.2.8 Оролцооны арга	a. Оролцооны арга ²⁹ гэж юу болохыг тайлбарлан жишээгээр үзүүлэх (суралцах, эрүүл мэндээ хамгаалах, засаглал, нөөц ашиглалтын менежмент гэх мэт); b. Шийдвэр гаргах, нийтийн маргаан шийдвэрлэлтэд малчдын оролцоог сайжруулахын ач холбогдлыг харилцан ярилцах.
5.3 Дижитал технологи ³⁰	5.3.1 Цаг агаарын урьдчилгаа мэдээ	a. Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээний ашиглалтын талаар жишээ хэлэх; b. Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээний дагуу өөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргах.

²⁶ <https://www.apo-tokyo.org/publications/wp-content/uploads/sites/5/Manual-on-Good-Agricultural-Practices-2016.pdf>

²⁷ <http://www.fao.org/3/a-as601e.pdf>

²⁸ <http://www.fao.org/3/a-i5125e.pdf> and <https://gggi.org/site/assets/uploads/2017/11/2015-02-Strategies-for-Development-of-Green-Energy-Systems-in-Mongolia-2013-2035.pdf>

²⁹ https://www.unescap.org/sites/default/files/pub_2308_part1.pdf

³⁰ <http://www.fao.org/3/ca4887en/ca4887en.pdf>

5



Дэвшилтэт технологи, арга барил ашиглах

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
5.3 Дижитал технологи	5.3.2 Малын гаралтай бүтээгдэхүүний үнийн мэдээлэл	<p>a. Үнийн мэдээлэл авах эх үүсвэрээ нэрлэх (малчин лавлах 109 гэх мэт);</p> <p>b. Ноос, ноолуур, мах, сүү зэрэг малын бүтээгдэхүүний зах зээлийн өнөөгийн үнэнд үнэлгээ хийх.</p>
	5.3.3 Цахим худалдаа	<p>a. Цахим худалдаа гэж юу болох түүнийг хэрхэн ашиглах тухай жишээ гаргах (цахимаар худалдаж авах, зарж борлуулах, шилжүүлэг хийх, бэлтгэх сүлжээний менежмент, маркетинг, мэдээлэл цуглуулах гэх мэт);</p> <p>b. Орон нутгийн түвшинд цахим худалдааг хөгжүүлснээр ямар үр өгөөж авчрах талаар харилцан ярилцах³¹ (хүнс, гар урлалын бүтээгдэхүүн худалдаалах, үржлийн мал авах/зарах гэх мэт).</p>
	5.3.4 Төрийн цахим үйлчилгээ	Орон нутгийн иргэдийн чухал хэрэгцээтэй үйлчилгээг цахимаар үзүүлж байгаа төрийн байгууллагыг нэрлэх.
	5.3.4 Төрийн цахим үйлчилгээ	<p>a. Орон нутгийн нөхцөлд чухал ач холбогдолтой төрийн байгууллагууд болон тэдгээрийн цахим үйлчилгээ үзүүлэх төрлөөр нь жагсаах;</p> <p>b. Цахимаар үйлчилгээ³² үзүүлж буй төрийн байгууллагуудын үйлчилгээг хэрхэн авах боломжтой болохыг хэлэх.</p> <p>c. Өргөдөл, гомдол, санал хүсэлт гаргах³³-ийн ойлголтыг тайлбарлах;</p> <p>d. Түүнийг орон нутгийн түвшинд хэрхэн ашиглах талаар ярилцаж жишээ гаргах.</p>
5.4 Насан туршийн боловсрол	5.4.1 Зарчмууд	<p>a. Насан туршийн боловсрол гэж юу болох яагаад чухал хэрэгтэй байгаа талаар тайлбарлах;</p> <p>b. Бие даан сурах аргуудаас жишээгээр тайлбарлах;</p> <p>c. Өөрийн давуу болон сул талуудыг тодорхойлж тэдгээрийг хэрхэн сайжруулж болох талаар ярилцах.</p>
	5.4.2 Харилцан суралцах /бие биеэсээ/	<p>a. Залуу болон туршлагатай ахмад малчид бие биеэс юу сурч болох тухай жишээ гаргах;</p> <p>b. Бие биеэсээ харилцан суралцаж³⁴ малчид малчидтайгаа мэдлэгээ хуваалцах аргуудыг ярилцах.</p>

³¹ жишээн нь: <https://www.taliinmongol.mn/product/available.html> or <https://www.facebook.com/khuvsgullake/?rc=p>

³² <https://e-mongolia.mn/home>

³³ <https://www.adb.org/sites/default/files/institutional-document/32956/files/grievance-redress-mechanisms.pdf>

³⁴ <https://youngfoundation.org/wp-content/uploads/2017/02/Share-to-Know-summary-guide.pdf> and [https://savethechildren.mn/uploads/publication/201802/Save the children JSDF Final Evaluation report.pdf](https://savethechildren.mn/uploads/publication/201802/Save%20the%20children%20JSDF%20Final%20Evaluation%20report.pdf)

5



Дэвшилтэт технологи, арга барил ашиглах

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
5.4 Насан туршийн боловсрол	5.4.2 Харилцан суралцах /бие биеэсээ/	Малчны хотны сургууль ³⁵ -ийн тухай тайлбарлаж өөрийн нутагтаа туршиж үзэх боломжийн талаар ярилцах (нүүдлийн мал аж ахуйн сургууль ³⁶ гэх мэт).
	5.4.3 Мэдлэгийн эх үүсвэр	а. Мэдлэгээ сайжруулах ³⁷ зорилгоор ашиглаж болох орон нутгийн, үндэсний болон олон улсын түвшний платформуудыг нэрлэх. б. Орон нутагт тулгарч байгаа бэрхшээлийг шийдвэрлэх аргуудыг платформуудаас хэрхэн олох талаар ярих.

³⁵ <http://www.fao.org/capacity-development/news-list/detail/en/c/883112/>

³⁶ <http://www.fao.org/3/a-bl492e.pdf>

³⁷ Жишээлбэл, дэлхийн түвшинд мал аж ахуй эрхлэгчдийн мэдлэгийн төв: <http://www.fao.org/3/a-i6410e.pdf>.



ЧАДАМЖ 6

ХУВИЙН АЖ АХУЙ ЭРХЛЭГЧ БОЛОХ

Зах зээлийн боломжуудыг хөгжүүлэх, судалж хэрэгжүүлэх мэдлэг, чадвар, чадамж эзэмшүүлнэ. Энэ нь зах зээлийн хандлага, менежмент, жижиг зээл авах боломж, маркетинг, ажлын байр бий болгох, зохион байгуулалт хийх, амьжиргааны эх үүсвэрийг төрөлжүүлэх зэрэг сэдвүүд хамаарна.

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
6.1 Хувь хүний үр чадвар	6.1.1 Алсын хараа ба зорилго	Нутагтаа мал маллах болон бусад талаар дэвшүүлж буй өөрийнхөө алсын хараа, зорилгоо тодорхойлох.
	6.1.2 Бүтээлч байдал	<ul style="list-style-type: none"> a. Бүтээлчээр сэтгэн бодох техник/ аргуудыг жагсаах (төсөөлөн бодох, гүйлгэн харах³⁸, Зургаан сэтгэлгээний малгай буюу олон янзын үзэл бодол, сэтгэлгээний хэв маягийг илэрхийлсэн эсэхийг баталгаажуулах замаар бүтээлч харилцан яриаг нэмэгдүүлэх арга); b. Өөрийн зорилгоо өөр өнцгөөс харж үнэлэхэд бүтээлчээр сэтгэн бодох техник аргуудаас ашиглах.
	6.1.3 Өөрийгөө ойлгох ба өөрийгөө үр бүтээмжтэй байлгах ³⁹	<ul style="list-style-type: none"> a. Богино, дунд, урт хугацааны хэрэгцээ, хүсэл, эрмэлзлээ эргэцүүлэн бодох; b. Өөрийгөө болон бүлгийн давуу, сул талыг тодорхойлж, үнэлэх; c. Тодорхой бус байдал, үхралт, түр зуурын бүтэлгүйтлийг үл харгалзан сургалтын явцад нөлөөлөх чадвараа үнэлэх.
	6.1.4 хөдөлмөрч шаргуу байх	<ul style="list-style-type: none"> a. Өөрийгөө идэвхжүүлэх аргуудыг нэрлэх; b. Дотоод идэвхжүүлэлтийг гадаадаас ялгах; c. Хэрхэн оновчтой зорилгоо тавих тухай тайлбарлах; d. Амжилттай аж ахуй эрхлэгч /энтерпрэйнэр/-ийг тодорхойлох шинжүүдээс нэрлэх (санаачилгатай, шинийг эрэлхийлэгч, аз туршсан, зорилгоо оновчтой тодорхойлдог, ажилдаа тууштай, харилцаа холбоо сайтай гэх мэт).
	6.1.5 Хариуцлага хүлээх чадвар	<ul style="list-style-type: none"> a. Хариуцлагын талаар тайлбарлаж, орон нутгийнхаа нөхцөл байдлаас эерэг жишээ татна уу; b. Бүтэлгүйтэлд бусдыг буруутгаж, шалтаг тоочиж байсан тохиолдлуудыг эргэцүүлэх; c. Үр дүнгийн төлөө хариуцлагаас зайлсхийх таны чадварыг бууруулж байгааг хүлээн зөвшөөрөх.

³⁸ https://www.mindtools.com/pages/article/newCT_02.htm, энэ холбоос хэд хэдэн өөр арга техникүүдийн талаарх ойлголтыг өгнө.

³⁹ <http://ecosystemapp.net/wp-content/uploads/2017/08/6-Self-awareness-and-self-efficacy.pdf>

6



Хувийн аж ахуй эрхлэгч болох

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
6.1 Хувь хүний ур чадвар	6.1.6 Ёсзүй	<p>a. Ёсзүй, ёс суртахуун гэж юу болох тухай тайлбарлаж өөрийн гаргаж байсан ёсзүйтэй болон ёсзүйгүй гэж үзсэн зангуудаасаа нэрлэх;</p> <p>b. Нэг бэрхшээлтэй асуудал жишээлж аваад түүнийг ёсзүйн талаас үнэлэх (уул уурхайн зориулалтаар газар ашиглах болсонтой холбогдуулан нутгийн иргэдийг нүүлгэн шилжүүлсэн гэх мэт жишээ);</p> <p>c. Илт маргаантай асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар харилцан ярилцах ингэхдээ засаглал, авлига хээл хахууль, гадуурхал, эрх мэдэл, нийгмийн хариуцлага зэргийг тооцох).</p>
6.2 Хүн хоорондын харилцааны ур чадвар		<p>Чадамж 7-г үзнэ үү.</p>
6.3 Бизнес	6.3.1 Зарчмууд	<p>a. Мал аж ахуй эрхлэлт бол өрхийн бизнес⁴⁰ гэдгийг ойлгож, тайлбарлах;</p> <p>b. Бизнес эрхлэхэд чухал шаардлагатай бүрэлдэхүүнүүдийг нэрлэх (маркетинг, үйл ажиллагаа явуулах, санхүүжилт, борлуулалт, хууль эрх зүйн орчин гэх мэт);</p> <p>c. Бизнес загваруудаас нэрлэх (ашиг төлөө, нийгэмд үйлчилдэг гэх мэт);</p> <p>d. Мал аж ахуйн бизнесийн эргэлтийн үе шатуудыг нэрлэх (зохион байгуулалт, үйлдвэрлэл, хяналт шинжилгээ, маркетинг гэх мэт);</p> <p>e. Мал аж ахуйн бизнес болон мал аж ахуйн үйлдвэрлэл хоёрын хоорондын ялгааг ойлгох;</p> <p>f. Үйлдвэрлэлийн төрлүүдийн ялгааг нэрлэх (өрсөлдөөн, нэмэлт, харилцан бие биеэ дэмжих);</p> <p>g. Мал аж ахуйн маркетингийг тайлбарлаж түүний өөр өөр хэлбэрүүдийн ялгааг тайлбарлах;</p>
	6.3.2 Шинжилгээ хийж төлөвлөх	<p>a. Өөрийн бизнес, маркетингийг бүтээгдэхүүний сүлжээний үе шатанд холбох, таниулах;</p> <p>b. Өөрийн сонирхсон эсвэл өгөгдсөн жишээн дээр бизнес төлөвлөгөө боловсруулах;</p> <p>c. Мал аж ахуйн бизнес эрхлэхээс өмнө хариулт олох шаардлагатай асуултуудыг жагсаах (тогтвортой газар ашиглалт, зах зээлийн хэрэгцээ, холбогдох мэдлэгтэй болох гэх мэт).</p>
	6.3.3 Хэрэгжилт	<p>a. Хэрэгжилтийн үе шатан дах чухал нөхцөлүүдийг тодорхойлох (гэрээ байгуулах, харьцуулалт, жишиг судалгаа, нэмүү өртөг шингээлт);</p> <p>b. Санхүүжилт шийдвэрлэх арга замуудыг тодорхойлох;</p>

⁴⁰ <http://www.fao.org/3/i2137e/i2137e00.htm>

6



Хувийн аж ахуй эрхлэгч болох

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
6.3 Бизнес	6.3.3 Хэрэгжилт	<p>c. Малчдад зориулсан ямар төрлийн зээлийн бүтээгдэхүүнүүд танай нутагт байгаа, түүнийг хэрхэн авах тухай харилцан ярилцах;</p> <p>d. Мал аж ахуйн бизнес эрхлэхэд шаардлагатай зүйлсийг бэлтгэх (үйлдвэрлэл, ажиллах хүч, мөнгөний урсгал, өрхийн хэрэглээ, алдагдал гэх мэт).</p>
	6.3.4 Үнэлгээ, хийж дүгнэлт гаргах	<p>a. Бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлэх;</p> <p>b. Орон нутагт бизнес эрхлэх боломж эвсэл өөрийн бизнест СВОТ шинжилгээ хийх.</p>
6.4 Эрсдэл	6.4.1 Зарчмууд	<p>Чадамж 8-ийг үзнэ үү.</p>
	6.4.2 Бизнесийн эрсдэлүүд	<p>a. Зээлийн тухай ойлголтыг тайлбарлаж түүний ач холбогдол болон эрсдэлүүдийг нэрлэх;</p> <p>b. Бизнесийн эрсдэлийг үнэлж түүнийг зохицуулах;</p> <p>c. Мал аж ахуйн бизнесийн ашиг орлогод юу нөлөөлж болохыг тодорхойлох (өрхийн хэрэглээ, зах зээлийн үнэ, өрсөлдөгчид, үйл ажиллагааны зардал, зээл, технологи гэх мэт);</p> <p>d. Эрсдэл, эрсдэлийг бууруулах стратегийг тус бүрд нь тодорхойлж тайлбарлах;</p> <p>e. Өгөгдсөн жишээний дагуу нөөц ашиглалт болон бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй холбоотой зөрчилтэй асуудалд шинжилгээ хийх;</p> <p>f. Үйлдвэрлэлийн түүхий материалын хангамж нийлүүлэлтээс шалтгаалах эрсдэлд зохицуулалт хийх (үр, бордоо, машин тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис гэх мэт).</p>
6.5 Эдийн засаг	6.5.1 Зарчмууд	<p>a. Эдийн засгийн суурь нөхцөлүүдийг тодорхойлох (эрэлт нийлүүлэлт, зардал, орлого, сонголт ба боломжийн зардал, үр өгөөж, түүхий эд материал, эцсийн бүтээгдэхүүн, ашгийн хувь, гадаад орчин гэх мэт);</p> <p>b. Мал аж ахуйн системтэй холбогдох түүхий эд материал, эцсийн бүтээгдэхүүнийг нэрлэх (түүхий эд материал: ус, тэжээл, вакцин, ажиллах хүч, үндсэн хөрөнгө; эцсийн бүтээгдэхүүн: мах, сүү, арьс шир, мал амьтан, өргөжин тэлэх чадвар, өтөг бууц, ноос ноолуур гэх мэт);</p> <p>c. Үр өгөөж/үржил шим гэдэг ойлголтыг тодорхойлж өөр өөр үр өгөөжийг хэмжих үзүүлэлтийн ялгааг харуулсан жишээ гаргаж тайлбарлах (амьдын жин, сүүний гарц, тэжээлийн шимт чанар);</p> <p>d. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн хувьсах зардал, тогтмол зардал хоёрын ялгааг гаргах.</p>
	6.5.2 Арга хэрэгслүүд	<p>a. Шинжилгээний нийтлэг аргуудыг нэрлэх (өртөг өгөөж, хүсэл сонирхлын, түүхий эд материал ба бүтээгдэхүүний шинжилгээ, ашгийн шинжилгээ, үйлдвэрлэлийн төсвийн шинжилгээ, бүхий аж ахуйн төсвийн үнэлгээ гэх мэт);</p>

6



Хувийн аж ахуй эрхлэгч болох

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
6.5 Эдийн засаг	6.5.2 Арга хэрэгслүүд	b. Өөрийн бизнесийн эсвэл өгөгдсөн жишээнд ашгийн дүн шинжилгээ хийж ашигтай байдлыг үнэлэх.
6.6 Санхүүгийн зарчмууд		<p>a. Хөрөнгө босгох арга зэргийг оролцуулан өөрийн бизнесийг санхүүжүүлэх арга замуудын талаар харилцан ярилцах;</p> <p>b. Хуримтлал үүсгэх болон хөрөнгө оруулалт хийх аргуудыг нэрлэх;</p> <p>c. Бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх нарийвчилсан төсвийн төсөл гаргах;</p> <p>d. Өгөгдсөн жишээнд бэлэн мөнгөний урсгалын орох, гарах шилжүүлэгт нягтлан бодох бүртгэл хөтлөх (мал аж ахуйн эсвэл өрхийн орлого, зарлага гэх мэт);</p> <p>e. Үйлдвэрлэл болон гүйцэтгэлийн үнэлгээнд санхүүгийн суурь шинжилгээ хийх (үнийн өөрчлөлт эсвэл гарцын тооцоолол гэх мэт).</p>
6.7 Хамтын бизнесийн менежмент		<p>a. Хамтын бизнесийн менежмент гэж юу болохыг тодорхойлох;</p> <p>b. Бусадтай хамтран ажиллахад анхаарах чухал зүйлсийг нэрлэх (зардал хуваах, хамтарсан шийдвэр гаргах, ил тод байх гэх мэт);</p> <p>c. Хамтын бизнесийн менежментийн арга барилыг орон нутагт хэрэгжүүлэх, турших талаар харилцан ярилцах.</p>
6.8 Нэмэлт орлого	6.8.1 Агро аялал жуулчлал	<p>a. Агро аялал жуулчлал гэж юу болохыг тайлбарлан малчид түүнийг хэрхэн ашиглаж болохыг тодорхойлох;</p> <p>b. Малчдын зүгээс жуулчдад санал болгож болох аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүдийг нэрлэх;</p> <p>c. Агро аялал жуулчлал хөгжүүлэх, үйл ажиллагаа явуулахад шаардлагатай зүйлсэд үнэлгээ өгөх (зар сурталчилгаа, аялал жуулчлалын агентлагуудтай хамтран ажиллах, гадаадын жуулчидтай харилцах хэлний шаардлага гэх мэт);</p> <p>d. Орон нутагтаа агро аялал жуулчлал хөгжүүлэх хамтын ажиллагааг бий болгох талаар харилцан ярилцах (бүлэг бизнесийн менежмент, сумын түвшний гэрээ, аялал жуулчлалын агентлагуудтай албан ёсны хамтын ажиллагаа гэх мэт).</p>
	6.8.2 Бүтээгдэхүүн, үйлчилгээ	<p>a. Дотооддоо үйлдвэрлэсэн мал аж ахуйн бүтээгдэхүүний талаар чадамж 4-ийг үзнэ үү;</p> <p>b. Мал аж ахуйн бүтээгдэхүүнээс гадна жуулчдын сонирхлыг татахуйц бусад бүтээгдэхүүнийг нэрлэх (уламжлалт сууц/гэр, морь унуулах, уламжлалт аргаар хоол, хүнс бэлтгэх, тэдгээрийг амтлуулах гэх мэт);</p> <p>c. Малын гаралтай дагавар бүтээгдэхүүнийг санал болгох, зах зээлийг сайжруулах талаар харилцан ярилцах.</p>



ЧАДАМЖ 7

ХАМТЫН ХАРИЛЦААГ ХӨГЖҮҮЛЭХ

Зорилго, зорилтоо биелүүлэхэд шаардлагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, бусадтай хамтран ажиллах мэдлэг, үр чадвар, чадамж эзэмшүүлнэ. Энэ нь өрсөлдөөний болон дэмжих хамтын ажиллагааны талаарх харах өнцөг, бусдын хувь нэмрийг үнэлэх, тэдгээрийг өөрийн үйл ажиллагаанд татан оролцуулах чадамжийг мөн агуулна.

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
7.1 Хувийн үр чадварууд		а. Чадамж 6-г үзнэ үү.
7.2 Харилцааны үр чадварууд	7.2.1 Харилцаа	а. Харилцааны арга замуудыг нэрлэх (аман, аман бус, идэвхтэй сонсогч); б. Ердийн нөхцөлд хэн нэгэнтэй төвөгтэй харилцаа үүсгэх гэдгийг тайлбарлах; с. Бусадтай үгээр харилцахаас өөр харилцааны хэлбэрийг ашиглах (биеийн хэлээр харилцах /биеийн хэлэмж гэх мэт); д. Харилцааны чухал ач холбогдолтой талуудын талаарх харилцан ярилцах (зорилтот үзэгчид, цаг хугацаа, хэлэх гэсэн гол утгадаа анхаарал хандуулах, анхаарлын төв гэх мэт).
	7.2.2 Итгэлцэл	а. Итгэлцэл яагаад чухал болох талаар харилцан ярилцаж орон нутагт тохирсон жишээ гаргах; б. Итгэлцэл бий болсон эсэхийг хэмжих үзүүлэлтийн талаар жишээ гаргах (хэрэгжүүлэх үйл ажиллагаанд бусдыг оролцуулах, хүрээлэн буй орчныг хамгаалах, шүүмжлэлийг хүлээн авах, бусдад итгэх илтгэлээ нэмэгдүүлэх гэх мэт).
	7.2.3 Мэдээлэл хуваалцах	а. Орон нутгийн түвшинд мэдээлэл хуваалцахын ач холбогдлыг тодорхойлох (гэр бүлийн гишүүд, малчид, бизнесийн хамтрагчид); б. Мэдээлэл хуваалцсаны үр өгөөжийн талаар харилцан ярилцах (зах зээлийн огцом өөрчлөлтөөс сэргийлэх, малын өвчнөөс урьдчилан сэргийлэх гэх мэт).
	7.2.4 Бусдыг ойлгох	а. Бусдыг ойлгох чадварыг тодорхойлж, өөрт тохиолдсон туршлагаас жишээ гаргах; б. Бусдыг ойлгох чадварыг илэрхийлэх жишээ гаргах (асуулт асуух, сэтгэгдэл хэлэх, өөрийн ялгаварлан гадуурхах үзлээ хянаж үзэх гэх мэт).

7



Хамтын харилцааг хөгжүүлэх

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
7.2 Харилцааны үр чадварууд	7.2.5 Гэрээ хэлцэл хийх	<ul style="list-style-type: none"> a. Гэрээ хэлэлцэл хийх чадвар гэж юу болохыг тодорхойлж яагаад чухал болохыг тайлбарлах (зорилгодоо хүрэх, стрессийн хүчин зүйлийг бууруулах, мөнгө, цаг хугацаа хэмнэх гэх мэт); b. Гэрээ хэлэлцэл хийх чадварыг сайжруулахад чухал нөлөөтэй хүчин зүйлсийг нэрлэх (тохиролцоо, зээл олгох, харилцан ашигтай байх аргачлал); c. Сонгосон сэдвээр хэлэлцэл хийх стратеги боловсруулах; d. Бусдын өмнөөс аливаа зөрчил, маргааныг дүрсэлж тайлбарлах; e. Түгээмэл тохиолддог маргаан зөрчлийг шийдвэрлэх орон нутагт хэрэглэгддэг аргуудын талаар харилцан ярилцах.
7.3 Маргаан, зөрчил шийдвэрлэх		<ul style="list-style-type: none"> a. Өөрт тохиолдож байсан зөрчил, маргаантай асуудлаар жишээ гаргах (газар, бэлчээр ашиглалтын өрсөлдөөн, ус ашиглалт, нүүдэл гэх мэт); b. Аливаа маргаан, санал зөрчилдөөнийг таних шинж тэмдгүүдийг нэрлэх; c. Түгээмэл тохиолддог маргаан зөрчлийг шийдвэрлэх орон нутагт хэрэглэгддэг аргуудын талаар харилцан ярилцах.
7.4 Арга механизмууд	7.4.1 Хоршоо	<ul style="list-style-type: none"> a. Хоршоо гэж юу болох, малчдад ямар үйлчилгээ үзүүлж чадах болохыг тайлбарлах; b. Хоршооны гишүүн байхын учрыг нэрлэх (түгээмэл тархацтай нөөцийн менежмент, гишүүдийн хувь нэмэр, хамтран үйл ажиллагаа явуулах); c. Танай нутагт үйл ажиллагаа явуулж байгаа хоршооны тухай болон түүнийг байгуулах боломжийн талаар харилцан ярилцах.
	7.4.2 Бэлчээр ашиглагчдын бүлэг	<ul style="list-style-type: none"> a. Бэлчээр ашиглагчдын бүлэг тухай тайлбарлах; b. Бэлчээр ашиглагчдын бүлгийн бүтэц, зохион байгуулалт (Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо⁴¹ гэх мэт).
	7.4.3 Бусад механизмууд	<p>Танай нутагт байгаа бусад төрлийн хамтын ажиллагааны механизмууд эсвэл байгуулснаар үр өгөөжтэй байх механизмуудын талаар бодож, харилцан ярилцах (төр-хувийн хэвшлийн түншлэл, арилжааны систем санаачлах, орон нутагт төвлөрсөн олон талын оролцоотой чанарын баталгааны систем)</p>
7.5 Нийгмийн сүлжээ		<ul style="list-style-type: none"> a. Нийгмийн сүлжээний оролцогчдыг тодорхойлох (гэр бүл, найзууд, хамтран ажиллагчид, холбоод, үндэсний болон олон улсын байгууллага); b. Мал аж ахуйн бизнес болон мал маллагааны арга технологийг сайжруулахад нийгмийн сүлжээг хэрхэн ашиглах талаар харилцан ярилцах.

⁴¹ <http://prize.equatorinitiative.org/wp-content/uploads/formidable/6/MNPUGs-introduction-to-scope-of-activities-and-Organizational-structure.pdf>



ЧАДАМЖ 8

ЭРСДЭЛИЙГ УДИРДАХ

Ган, зуд зэрэг байгалийн эрсдэл болон хүний хүчин зүйлээр үүсгэгдсэн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах мэдлэг, ур чадвар, чаламжийг эзэмшүүлнэ.

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
8.1 Зарчим		<ul style="list-style-type: none"> a. Эрсдэл гэж юу болохыг тодорхойлж эрсдэлийн төрлүүдийг нэрлэн жишээ гаргах⁴²; b. Аюулт үзэгдлийг эрсдэлээс ялгах таних; c. Танай нутагт малчдад тохиолддог эрсдэлийн талаар жишээ гарган ярилцах; d. Мал аж ахуйд тохиолддог эрсдэлүүдийг нэрлэх (цаг агаарын гэнэтийн үзэгдэл, малын тэжээлийн үнийн хэлбэлзэл, өвчний тархалт гэх мэт).
8.2 Шийдвэр гаргалт		<ul style="list-style-type: none"> a. Тодорхойгүй байдал болон эрсдэлийн үед гаргах шийдвэрийн талаар жишээ гаргах; b. Сайн шийдвэр гаргахад чухал шаардлагатай үе шатуудыг тодорхойлох (мэдээлэл цуглуулах, бусад боломжуудыг тодорхойлох, нотолгоо баримтад суурилах, үр дүнд үнэлгээ хийх); c. Гаргасан шийдвэрт шинжилгээ хийх практик арга хэрэгслүүдийг нэрлэх (мэдрэмтгий байдал/ хүлээн авах чадвар/-ийн шинжилгээ, үр ашгийн шинжилгээ, шийдвэрийн модны шинжилгээ, төлбөрийн хүснэгт).
8.3 Гэнэтийн үзэгдэл ба эрсдэлүүд	8.3.1 байгалийн эрсдэл	<ul style="list-style-type: none"> a. Байгалийн эрсдэлийн төрлүүдийг тодорхойлох (ган, зуд гэх мэт); b. Орон нутагт тохиолддог эрсдэлийг бууруулах арга замуудыг тодорхойлох (өвөл-хаврын өвс тэжээлийн нөөц бэлтгэх, орлогын төрөлжүүлэлд, бие даасан байдал, эрт мэдээлэх систем); c. Байгалийн нөөцийн дутагдалтай холбоотой эрсдэлийг зохицуулах талаар харилцан ярилцах (түймэр, талхагдлаас үүдэлтэй бэлчээрийн доройтол гэх мэт).
	8.3.2 Хүний хүчин зүйлээр үүсгэгдсэн	<ul style="list-style-type: none"> a. Танай нутагт тохиолддог эрсдэлүүдийг байгалийн болон хүний хүчин зүйлээр үүсгэгдсэн эсэхийг ялгаж тодорхойлох;

⁴² <http://www.fao.org/3/i0412e/i0412e02.pdf>

8



Эрсдэлийг удирдах

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
8.3 Гэнэтийн үзэгдэл ба эрсдэлүүд	8.3.2 Хүний хүчин зүйлээр үүсгэгдсэн	<p>b. Хүний хүчин зүйлээр үүсгэгдсэн эрсдэл/аюулт үзэгдлийн талаар жишээ гаргах (зэвсэгт мөргөлдөөн, зах зээлийн шок, талхагдал, бэлчээрийг өнжөөхгүй ашиглах, нүүдлийн хязгаарласан бодлогууд нь бэлчээрийг тогтворгүй ашиглах нөхцөлийг бүрдүүлж байгаа гэх мэт);</p> <p>c. Бэлчээрийн талхагдал, доройтлын эрсдэлд малчид эерэг болон сөрөг байдлаар хэрхэн хувь нэмэр оруулж болохыг тодорхойлох.</p>
8.3 Аюулт үзэгдэл, эрсдэл	8.3.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал	<p>a. Хөдөлмөрийн аюулгүй байдал, нөхцөл байдлыг сайжруулж болохуйц талаас нь тайлбарлах (жишээлбэл, мотоцикл, мал маллах, малтай харьцах, мал төхөөрөх);</p> <p>b. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайжруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэрлэх(жишээлбэл хувийн хамгаалалт, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, ажиллах дадал зуршил).</p>
	8.3.4 Өрхийн түвшний	<p>a. Өрхийн хэмжээнд гарах эрсдэлүүдийг нэрлэх (хүнсний, архины хэрэглээ, бохирдол, хүчирхийлэл гэх мэт);</p> <p>b. Өрхийн гишүүдийн эрүүл мэнд, тухлаг байдлыг хэрхэн хангадаг талаар жишээ гаргах (хооллолт болон эрүүл мэндийн боловсрол, эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэх, тогтмол эрүүл мэндийн үзлэгт хамрагдах);</p> <p>c. Өрхийн гишүүдэд хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд туслах эсвэл үнэлгээ хийх үйлчилгээнүүдийг нэрлэх.</p>
8.4 Хөдөө аж ахуйн эрсдэлийн менежмент ⁴³	8.4.1 Зарчим	<p>a. Эрсдэлийг үнэлэх аргуудын ялгааг тодорхойлох (албан бус шинжилгээ болон албан ёсны үнэлгээний аргууд гэх мэт);</p> <p>b. Эрсдэлийн менежментийн аргуудыг тодорхойлон ярилцах (бууруулах болон даван туулах стратеги гэх мэт);</p> <p>c. Хөдөө аж ахуйн эрсдэлийн менежментийн⁴⁴ арга хэрэгслүүдийг нэрлэх;</p> <p>d. Өгөгдсөн жишээнд зориулан хяналтын стратегиудаас сонгон үнэлгээ хийж турших (жишээ нь: Паразитыг хянах эсвэл хянахгүй орхих; үүнд адилхан жишээг ашиглах буюу вакцинжуулах, тэсвэртэй сайн үүлдрийн малаар сүрэг сэлбэж болох юм);</p> <p>e. Танай нутагт тохиолддог эрсдэлийг хэрхэн үнэлж хариу арга хэмжээ авдаг талаар жишээ гаргах (уур амьсгалд дасан зохицсон ухаалаг хөдөө, хөдөө аж ахуйн төрөлжилт, хөрөнгө болон орлогод суурилсан стратеги гэх мэт);</p>

⁴³ Мал аж ахуйн яаралтай тусламжийн удирдамж, стандарт: <https://www.livestock-emergency.net/download-legs/>

⁴⁴ НҮБ-ын ХХААБ-ын цахим сургалт “Хөдөө аж ахуйн эрсдлийн менежментийн хэрэгсэл”: <https://elearning.fao.org/mod/scorm/player.php?scooid=961&cm=777>

8



Эрсдэлийг удирдах

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
8.4 Хөдөө аж ахуйн эрсдэлийн менежмент	8.4.1 Зарчим	<p>f. Эрсдэлийн менежментийн арга хэрэгслүүдээс санхүүжилттэй холбоотой жишээ гаргах (даатгал, цаг агаарын индексэд суурилсан даатгал, хөдөө аж ахуйн санхүүжилт болон бичил санхүүжилт гэх мэт);</p> <p>g. Үйл ажиллагааны төрөлжилтийг малчдын эрсдэлийг бууруулах стратеги байдлаар ойлгож харилцан ярилцах.</p>
8.5 Яаралтай тусламж /хариу арга хэмжээ/	8.5.1 Зарчим	<p>a. Яаралтай хариу арга хэмжээ гэж юу болохыг тодорхойлж орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлдэг арга хэмжээний талаар жишээ гаргах (удаан, хурдан, хосолмол гэх мэт);</p> <p>b. Үнэлгээ хийж хариу арга хэмжээ авах сонголтын талаар жишээ гаргах (ачааллыг бууруулах, мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах, тэжээл/усан хангамж, хашаа хороо гэх мэт);</p> <p>c. Удаан хариу арга хэмжээний тухай жишээ гаргаж /зуд/, авах арга хэмжээг тодорхойлох.</p>
8.5 Яаралтай тусламж /хариу арга хэмжээ/	8.5.2 Гамшгийн эрсдэлийг бууруулах	<p>a. Гамшгийн эрсдэлийг бууруулах стратеги гэж юу болохыг тодорхойлж, түүний зарчмуудыг нэрлэх (бэлэн байдал, магадалшгүй ажлын төлөвлөгөө, эрт сэргийлэх арга хэмжээ г.т);</p> <p>b. Гамшгийн эрсдэлийг бууруулах стратегиудаас жишээ татан тайлбарлах (хөрөнгөд суурилсныг орлогод суурилсантай харьцуулах гэх мэт);</p> <p>c. Мал сүргийн тоог ихээр өсгөх арга хэмжээг эрсдэлийг бууруулах стратегийн талаас үнэлгээ хийх (цаг агаарын гэнэтийн шок болон даатгалын үйлчилгээг харьцуулах);</p> <p>d. Гамшгаас хамгаалахад шаардлагатай мэдээллийн эх үүсвэрүүдийг нэрлэх (цаг агаар урьдчилсан мэдээ, эрт мэдээлэх систем болон НҮБ-ын ХХААБ-ын дэлхийн мэдээллийн систем гэх мэт);</p> <p>e. Малын индексжүүлсэн даатгалын үр өгөөжийн талаар харилцан ярилцах;</p> <p>f. Орон нутгийн хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах эрт мэдээлэх механизмыг⁴⁵ хөгжүүлэх талаар харилцан ярилцах.</p>

⁴⁵ https://www.unisdr.org/files/608_10340.pdf



ЧАДАМЖ 9

ДЭЛХИЙН ХЭМЖЭЭНД СЭТГЭХҮЙ

Хөгжлийн тухай ойлголт, түүний гол үзүүлэлтүүдийг үндэсний, бүс нутгийн болон дэлхийн түвшинд ойлгох мэдлэг, чадвар, чадамж эзэмшүүлнэ.

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
9.1 Дэлхийн болон бүс нутгийн хөгжил	9.1.1 Дэлхийн хөгжлийн хандлага	<p>a. Дэлхийн хөгжлийн голлох үзүүлэлтүүдийг нэрлэх (хүн амын өсөлт, уур амьсгалын өөрчлөлт, тэгш байдал, хүнсний хаягдал, байгалийн нөөцийн эрчимтэй ашиглалт, өвчлөл, шинэ технологи гэх мэт);</p> <p>b. Дэлхийн хөгжил, өөрчлөлт таны өдөр тутмын амьдралд хэрхэн нөлөөлж болохыг тодорхойлох.</p>
	9.1.2 Бүс нутгийн хөгжлийн хандлага	<p>a. Ази тивийн хөгжлийн голлох үзүүлэлтүүдийг нэрлэх (газарзүйн байрлал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ, хил дамнан халдварлах өвчин, зах зээлийн хандлага, хэрэглэгчдийн сонголт гэх мэт);</p> <p>b. Бүс нутгийн мах, сүү зэрэг мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний зах зээлийг өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан үнэлэх.</p>
	9.1.3 Үндэсний хөгжлийн хандлага	<p>a. Монгол Улсын хөгжлийн голлох үзүүлэлтүүдийг нэрлэх (хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн, агаарын температур, хур тунадасны өөрчлөлт, хөдөөгийн хүн амын насжилт, орон нутаг дахь ажиллах хүчний хомсдол, мал сүргийн өсөлт, байгалийн нөөцийн хомсдол гэх мэт);</p> <p>b. Өнөөгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд нийцүүлэн мал аж ахуйн менежментийг өөрчлөх боломжийн талаар харилцан ярилцах.</p>
	9.1.4 Зах зээлийн хандлага	<p>a. Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн хандлагыг тодорхойлох (малын тэжээл, малын гаралтай хүнсний бүтээгдэхүүн болон түүхий эд гэх мэт);</p> <p>b. Мал аж ахуйн зах зээл болон нэмүү өртгийн сүлжээнд хэрхэн идэвхтэй хамтран ажиллах талаар харилцан ярилцах.</p>
	9.1.5 Малын гаралтай бүтээгдэхүүний хандлага	<p>a. Зах зээл дээр эрэлттэй байгаа бүтээгдэхүүнтэй өөрийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийг харьцуулах;</p> <p>b. Таны үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний бусад Улсын болон бүс нутгийн хэмжээнд үйлдвэрлэгдэж байгаа ижил төрлийн бүтээгдэхүүнээс ялгарах онцлог шинжийн талаар харилцан ярилцах (үүлдэр, ургац/ашиг шимт амт чанар, бэлчээрээр малладаг учир хэрэглэгчдийн сонголтод илүү тохиромжтой г.т).</p>

9



Дэлхийн хэмжээнд сэтгэхүй

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
9.2 Тогтвортой хөгжлийн тухай ойлголт	9.2.1 Зарчим	Тогтвортой хөгжил гэдгийн өөрсдийн ойлголтоор тайлбарлах (Брундтландын тодорхойлолт эсвэл НҮБ-ын ⁴⁶ ХХААБ-ын ⁴⁷ тодорхойлолт).
	9.2.1 Зарчим	a. Тогтвортой хөгжлийн 3 тулгуурыг өөрийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх (Эдийн засаг, нийгэм, байгаль орчин); b. Таны одоогийн үйл ажиллагаанаас тогтвортой хөгжил эергээр болон сөргөөр нөлөөлж болох эсэх талаар харилцан ярилцах.
	9.2.2 Гадаад байдал ба нийтийн хэрэглээний бараа	a. Гадаад байдал ба нийтийн хэрэглээний барааны тухай ойлголт; b. Орон нутгийн нөхцөл байдлаас харахад мал аж ахуйг гадаад хүчин зүйлсийн жишээ татах(жишээлбэл, амьтны гаралтай хог хаягдлыг гол, жалга, шуудуунд хаях); c. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн онцлог шинж чанар (эерэг, сөрөг) (ландшафт, биологийн олон янз байдал, нүүрстөрөгчийн давхар исэл ба метан хий ялгаруулах, тааламжгүй үнэр, амьтны тавлаг байдал)-ийг нэрлэх; d. Орон нутгийнхаа нөхцөлд гадаад хүчин зүйлс болон нийтийн хэрэгцээний барааг хэрхэн илүү сайн зохицуулах талаар ярилцана уу. (жишээлбэл, тухайн бүс нутгийн малчдын дунд хэлэлцээр хийх эсвэл засгийн газраас хууль тогтоох шаардлагатай байна).
	9.2.3 Мал аж ахуйн бүтээгдэхүүний давуу тал	Мал аж ахуйн давуу талыг тодорхойлон ярилцах (хөдөөгийн иргэдийн хүнсний хангамж болон амьжиргаанд чухал үүрэгтэй байхын зэрэгцээ байгаль хамгаалах, өсгөлөн, ядуурлыг бууруулахад голлох нөлөөтэй болох тухай).
	9.2.4 Агро экологи	a. Агро экологийн ⁴⁸ 10 элементийг нэрлэх ⁴⁹ ; b. Өөрийн үйл ажиллагааг агро экологийн элементүүдтэй харьцуулан үнэлгээ өгөх; c. Мал аж ахуй, газар тариаланг хослуулан хөгжүүлснээр гарах боломжит үр дүнгийн талаар харилцан ярилцах; d. Орон нутгийн байдлыг илүү сайн ойлгох үүднээс агро экологийн шинжилгээ хийж үзэх.
9.2.5 маргаантай сэдэв	Танай нутагт байдаг аль нэг маргаантай сэдвийг сонгон авч түүнийг өөрийн үзэл бодлоор тайлбарлах (уур амьсгалын өөрчлөлтөд мал аж ахуй үзүүлэх нөлөө, хүнс эсрэг малын тэжээл, малын тавлаг байдал, хөдөө аж ахуйн эрчимжүүлэлт).	

⁴⁶ Тогтвортой хөгжлийн зорилтууд: <https://www.un.org/sustainabledevelopment/>

⁴⁷ Хүнс, хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийн таван үндсэн зарчим (ХХААБ, 2020): <http://www.fao.org/sustainability/en/>

⁴⁸ <http://www.fao.org/3/i9037en/i9037EN.pdf>

⁴⁹ <http://www.fao.org/3/i9037en/i9037EN.pdf>

9



Дэлхийн хэмжээнд сэтгэхүй

СЭДЭВ	ДЭД СЭДЭВ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
9.2 Тогтвортой хөгжлийн тухай ойлголт	9.2.6 Байгаль хамгаалал	<p>a. Байгаль хамгаалал гэж юу болохыг тодорхойлж малчид, мал аж ахуйтай хэрхэн холбогдох талаар ярилцах;</p> <p>b. Таны ойр орчимд байгаа байгаль хамгаалах санаачилгуудыг хооронд нь харьцуулж харилцан ярилцах.</p>
9.3 Нэг эрүүл мэнд	9.3.1 Зарчим	<p>a. Таны гэр бүл, мал сүрэг болон байгаль орчны хоорондын харилцан хамаарлын талаар жишээ гарган ярилцах;</p> <p>b. Нэг эрүүл мэндийн 3 ойлголт (хүн-мал-байгаль орчин) тус бүрээр жишээ гаргах;</p> <p>c. Өөрийн үйл ажиллагаанд үнэлгээ өгч нэг эрүүл мэндэд үзүүлж болох эрсдэлийн жишээ гаргах.</p>
	9.3.2 Нянгийн тэсвэржилт	<p>a. Антибиотик гэж юу болохыг тайлбарлаж ямар тохиолдолд үр дүнтэй байдаг тухай ярилцах;</p> <p>b. Малд антибиотик хэрэглэснээр гарах үр дагаврыг тодорхойлох (малын гаралтай бүтээгдэхүүн дэх антибиотикийн үлдэгдэл, бактерийн тэсвэржилт, эмийн гадагшлах хугацаа);</p> <p>c. Антибиотикийн үлдэгдлийн хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдэлийг тодорхойлох;</p> <p>d. Малчид мал аж ахуйн мэргэжилтнүүд антибиотикийн үлдэгдлээс сэргийлэх үйл ажиллагаануудыг нэрлэх (зөвхөн антибиотик худалдаалах эрхтэй этгээдээс эм авах, зөвхөн зааврын дагуу хэрэглэх, эмийн гадагшлах хугацааг чанд мөрдөх, өсөлтийг дэмжих зорилгоор антибиотикийн хэзээ ч хэрэглэхгүй байх, малыг мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх үйлчилгээнд тогтмол хамруулах, өвчтэй малыг тусгаарлаж халдваргүйжүүлэх арга хэмжээ авах гэх мэт);</p> <p>e. Урьдчилан сэргийлэх нь эмчлэхээсээ илүү байдаг талаар харилцан ярилцах (олон талаас харж ажиллахын давуу талууд жишээлбэл малын эрүүл мэнд, ашиг орлого, цаг хугацаа гэх мэт).</p>
9.4 Нийтийн өмчийн засаглал		<p>a. Нийтийн өмчийн эмгэнэл гэж юу болохыг тайлбарлаж жишээ гаргах;</p> <p>b. Сайн дурын зөвлөмж, орон нутгийн түвшний гэрээнүүдээр дамжуулан нийтийн өмчийг зохистой ашиглах талаар ярилцах⁵⁰.</p>

⁵⁰ Хариуцлагатай засаглалын сайн дурын удирдамж: <http://www.fao.org/3/i2801e/i2801e.pdf>

ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЗӨВЛӨМЖ

Энэхүү чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр нь Монгол Улсын мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийн сэдвүүдийг төдийгүй дэлхийн хөгжлийн ерөнхий хандлагыг хамруулсанаараа онцлогтой юм. Эдгээр нь малчин өрх байгалийн нөөцийг тогтвортой, үр өгөөжтэй ашиглан мал аж ахуйг бизнес болгон хөгжүүлэхэд чухал шаардлагатай сэдвүүд болно. Энэ сургалтын хөтөлбөр нь уламжлалт мал аж ахуйг орчин үеийн дэвшилтэт технологи шингэсэн мал аж ахуйтай хослуулан хөгжүүлэх энгийнээс эхлээд нарийн мэргэжлийн арга барил, менежментийг багтаасан болно. Ийнхүү өргөн хүрээний сэдвийг оруулж

өгснөөр төрийн болон бус олон байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлэх боломжийг олгож байна. Тухайлбал: мах боловсруулах үйлдвэр энэхүү хөтөлбөрийн 4 дүгээр сэдвийн сонгон өөрсдийн бэлтгэн нийлүүлэгчдээ сургалт зохион байгуулан зөв аргаар анхан шатны тордлого ажиллагаа хийсэн, чанартай түүхий эд нийлүүлүүлэх боломжтой.

Үр өгөөжтэй, хүртээмжтэй сэдвүүдийг агуулсан хичээлүүдийг хүлээн авснаар малчид өөрт шаардлагатай мэдлэг, чадвар, чадамжийг эзэмшиж өдөр тутмын амьдралдаа нэвтрүүлэх сонголтыг олгож байна.



Хэрэгжүүлэх бодлого

Энэхүү сургалтын хөтөлбөр нь НҮБ-ын Хүнс, Хөдөө аж ахуйн байгууллага, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд боловсруулагдсан. Тиймээс захиалагч байгууллага болох НҮБ-ын ХХААБ-аас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлж батлуулах хэрэгтэй. ХХААХҮЯамны холбогдох газар нь түүнийг хүлээн авч шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд болон сайдад танилцуулан батлуулах арга хэмжээ авах нь зүйтэй. Хэрэв ХХААХҮ-ийн сайд, удирдах албан тушаалтнууд дэмжсэн тохиолдолд энэхүү сургалтын хөтөлбөрийг одоо хэрэгжиж байгаа болон цаашид хэрэгжих төслүүд, хамтран ажилладаг олон улсын болон бусад байгууллагуудад санал болгон хамтран хэрэгжүүлэх боломжтой юм. Энэ нь сургалтын хөтөлбөрийг богино хугацаанд Улсын хэмжээнд амжилттай хэрэгжүүлэх стратеги болох юм.



Сургалт зохион байгуулах бодлого

Сургалтын хөтөлбөр нь суралцагчид суурилсан арга барилд зориулан боловсруулсан тул сургалт зохион байгуулах гарын авлага нь мөн насанд хүрсэн суралцагч малчид төвтэй байдлаар бэлтгэгдсэн байх шаардлагатай. Сургалтын үндсэн зорилго нь малчдад асуудлыг өргөн өнцгөөр харж өөрсдийн хандлагаа өөрчлөх, тулгарч буй асуудлаа мэдлэг мэдээлэлд тулгуурлан ухаалгаар шийдвэрлэх чадамж эзэмшүүлэхэд оршино.

Сургалтын хөтөлбөрийг зохих дэс дараалалтай судлахаар төлөвлөн боловсруулсан. Эхний бүлэг нь мал аж ахуйн салбарын гол орц болох байгалийн нөөц ашиглалт, хоёрдох нь бэлчээрийн менежмент, байгаль хамгаалал болон бусад бэлтгэл, гуравдах нь малын тэжээл, үржүүлэг, мал эмнэлэгийн үйлчилгээ зэрэг мал аж ахуйн менежментийг хэрхэн хэрэгжүүлэх арга замыг тус тус тайлбарласан. Эдгээр гурван бүлэг сэдэв нь заавал судлах сэдэв бол үлдсэн нь сонголтоор судлах боломжтой. Өөрөөр хэлбэл нэг байгууллага үйл ажиллагааны хүрээнд дөрөвдүгээр бүлэг сэдвийг сонгон захаар болоход тэд дээр дурдсан эхний 3 бүлэг сэдвийг судлуулсны дараа 4 дүгээр бүлэг сэдвээ үргэжлүүлэн заах жишээтэй.

Тухайн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж буй байгууллага бүр сургалт зохион байгуулсан газар, хамрагдсан малчдын тоог Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд улирал тутамд тайлагнах үүрэг хүлээнэ. Ингэснээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь уг сургалтын хөтөлбөрийг дараагийн улиралд хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргах болон өмнөх улирлын төлөвлөгөөний биелэлтийг гаргаж хяналт тавин ажиллах боломжийг олгох болно. Ийнхүү тайлагнаж ажиллах нь сургалт зохион байгуулсан байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллага болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хоорондын ажлын уялдааг сайжруулж хамтын ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх давуу талтай болно.

Сургалтыг сургалтын танхим, танхимд гэхээсээ илүү орон нутагт малчны хотонд зохион байгуулахыг илүүд үзэх хэрэгтэй. Түүнчлэн, сургалт зохион байгуулах сургалтын арга нь боловсролын хувьд харилцан адилгүй, мал малласан жилийн хувьд зөрүүтэй насанд хүрэгсдэд зориулсан загвартай байхыг бид зөвлөж байна. Сургалтын хөтөлбөрийн 5-9 дүгээр бүлэг сэдвүүдийн хүрээнд малчид бие биенээсээ суралцах харилцан мэдлэг, туршлагаа хуваалцах боломжийг олгож байгаараа мөн онцлог юм.

ТАЛАРХАЛ

Энэхүү сургалтын хөтөлбөрийг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын захиалгаар Монгол Улсын мал аж ахуйн тогтвортой хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулах гэрээний хүрээнд боловсруулагдсан тул энэ ажилд оролцож хамтран ажилласан бүх байгууллага хамт олонд талархал илэрхийлж байна. Ялангуяа НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Монгол дах суурин төлөөлөгчийн газрын хамт олонд гүн талархал илэрхийлье.

Сургалтын хөтөлбөр боловсруулах ажлыг санхүүжүүлж хамтран ажилласан Даян дэлхийн тогтвортой мал аж ахуйн хөтөлбөрт мөн талархал илэрхийлж байна. Бидний талархал нь зөвхөн сургалтын хөтөлбөр боловсруулах ажлыг санхүүжүүлсэнд бус шаардлагатай мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч Монгол Улсын мал аж ахуйн тогтвортой хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байгаад талархан хүлээн авч байна.

Энэхүү сургалтын хөтөлбөрийг туршихад санал өгч сайжруулсан Завхан аймгийн Идэр сумын удирдлага, малчдад талархал илэрхийлье. Түүнчлэн Монгол Улсын мал аж ахуйн тогтвортой хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хамтран ажилладаг байгууллагууд та бүгд зөвлөлдөх уулзалт хэлэлцүүлгийн үеэр үнэтэй зөвлөгөө, шинэлэг санаа өгч хамтран ажилласанд тусгайлан талархал илэрхийлж байна. Эдгээр хувь нэмрүүд тань бидний хэрэгжүүлж буй хөгжлийн төлөвлөгөөг бодитой болгоход томоохон нөлөө үзүүлсэн гэдгийг дурьдмар байна.

**Монголын тогтвортой хөдөө аж ахуйн
судалгаа, хөгжлийн төв ТББ**

COMPETENCE

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ



- Addison, J., Davies, J., Friedel, M., Brown, C., 2013. Do pasture user groups lead to improved rangeland condition in the Mongolian Gobi Desert? *Journal of Arid Environments* 94, 37–46.
- Asian Development Bank, 2013. Making grasslands sustainable in Mongolia: Adapting to climate and environmental change. Asian Development Bank, Mandaluyong City, Metro Manila, Philippines, 60 pp.
- Agroecology Knowledge Hub. (n.d.). *The 10 Elements of Agroecology*. Retrieved from <http://www.fao.org/agroecology/knowledge/10-elements/en/>
- Draft law on pastureland utilization and welfare (2019). Drafted by Ministry of Food, Agriculture and light industry.
- Edmeades, D.C., 2003. The long-term effects of manures and fertilizers on soil productivity and quality: a review. *Nutrient Cycling in Agroecosystems* 66 (2), 165– 180.
- Fernandez-Gimenez, M.E., Batkhisig, B., Batbuyan, B., Ulambayar, T., 2015. Lessons from the dzud: Community-based rangeland management increases the adaptive capacity of Mongolian herders to winter disasters. *World Development* 68, 48–65.
- Fernandez-Gimenez, M.E., 2000. The role of Mongolian nomadic pastoralist's ecological knowledge in rangeland management. *Ecological Applications* 10 (5), 1318–1326.
- Fernandez-Gimenez, M.E., 2006. Land use and land tenure in Mongolia: A brief history and current issues. USDA Forest Service Proceedings RMRS-P-39, 30-36. Retrieved from: <http://www.treesearch.fs.fed.us/pubs/22866>.
- Food and agricultural organization of the United Nations. (2017). Publishing at FAO strategy and guidance. Published by Office for communication and publication branch. Retrieved from Publications | Food and Agriculture Organization of the United Nations (fao.org)
- Food and agricultural organization of the United Nations. (2017). Nutrition-sensitive agriculture and food systems in practice Options for intervention. ISBN 978-92-5-109945-2.
- Food and agricultural organization of the United Nations. (n.d.). 5 key principles of sustainability for food and agriculture. Retrieved from <http://www.fao.org/sustainability/en/>.
- Gendaram, H., 2009. Animal feed and feeding. Munkhiin Useg Group Ltd, Ulaanbaatar, Mongolia, 247 pp.
- Global Agenda for Sustainable Livestock (GASL). (n.d.). *Global Agenda for Sustainable Livestock*. Retrieved from <http://www.livestockdialogue.org>

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ



- Global Agenda for Sustainable Livestock (GASL). (n.d.). *Global Agenda for Sustainable Livestock*. Retrieved from <http://www.livestockdialogue.org>.
- INTER-RÉSEAUX. (n.d.). *Pastoral Livestock Farming in Sahel and West Africa 5 - Preconceptions put to the test*. Retrieved from <http://www.inter-reseaux.org/IMG/pdf/int-17-broch-pastoralismeuk-bd.pdf>
- Jonathan, D., Pedro, H., Jabier, R.M., Jennifer, M.K., Ian, H., Emmanuel, N., 2016. Improving governance of pastoral lands Implementing the Voluntary Guidelines on the Responsible Governance of Tenure of Land, Fisheries and Forests in the Context of National Food Security. ISBN 978-92-5-109292-7.
- Juan Izquierdo, Marcos Rodriguez Fazzone, Marcela Duran. (2007). *Guidelines Good Agricultural Practices for Family Agriculture*. ISBN 978-92-5-105757-5.
- Law on livestock number tax (2020). Approved by Monolian parliament.
Law on animal genetic resources (2017). Approved by Monolian parliament
Law on animal health (2017). Approved by Monolian parliament
- Liniger, H., & Mekdaschi Studer, R. (2019). *Sustainable rangeland management in Sub-Saharan Africa – Guidelines*. TerrAfrica; World Bank, Washington D.C.; World Overview of Conservation Approaches and Technologies. Retrieved from <https://www.wocat.net/library/media/174/>
- Lkhagvadorj, D., Hauck, M., Dulamsuren, C., Tsogtbaatar, J., 2013b. Twenty years after decollectivization: Mobile livestock husbandry and its ecological impact in the Mongolian forest-steppe. *Human ecology* 41 (5), 725–735.
- Middleton, N., Rueff, H., Sternberg, T., Batbuyan, B., Thomas, D., 2014. Explaining spatial variations in climate hazard impacts in western Mongolia. *Landscape Ecology* 30, 91–107.
- Ministry of Food, Agriculture and Light Industry. (2018). *Mongolian Agenda for Sustainable Livestock*. Retrieved from <http://masl.mofa.gov.mn>.
- Ministry of Food, agriculture and light industry, (2020). Mongolian strategy for 5 types of livestock breeding.
- Approved by A-15th order of Minister for Food, agriculture and light industry.
- Mette Vaarst (2015). The Role of Animals in Eco-functional Intensification of Organic Agriculture. *Sustainable Agriculture Research*; Vol. 4, No. 3; 2015 ISSN 1927-050X E-ISSN 1927-0518 Published by Canadian Center of Science and Education. doi:10.5539/sar.v4n3p103.
- Mongolian parliament, (2020). Vision 2050 long term policy document. Approved by 52nd resolution of Mongolian Parliament.
- Mongolian Government, (2016). Action plan for implementing green development policy. Approved by 35th resolution of Mongolian Government.
- Mongolian Government, (2019). National determined contribution to implementation of Paris agreement. Approved by 407th resolution of Mongolian Government.
- Nergui, D., Jigjidpurev, S., Otgo, T., Dugersuren, S., Lkhagvajav, D., Enkhtsetseg, B. (Eds.), 2011. Animal feed and feeding research. Review for the 50th anniversary of the Mongolian Institute of Animal Husbandry. Munkhiin Useg Group LLC, Ulaanbaatar, Mongolia, 664 p.
- Otgonjargal, A., 2012. Nutritive value, methane and carbon dioxide production from pastures of mountainous steppe. (Doctoral dissertation in Mongolian language). Mongolian State University of Agriculture, Ulaanbaatar, Mongolia, 124 p.
- Sharma, K., Davaakhuu, O., 2015. Trade policymaking in a resource-rich landlocked country: The WTO review of Mongolia. *The World Economy* 38 (9), 1350–1367.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ



- Thornton, P.K., 2010. Livestock production: Recent trends, future prospects. Philosophical Transactions of the Royal Society of London B: Biological Sciences 365 (1554), 2853–2867.
- Togtokhbayar, N., 2006. Evaluation of pasture forages as livestock feed. In: Makkar, H.P.S., Smith, T. (Eds.), Improving animal productivity by supplementary feeding of Vegetation quality and quantity along the grazing itineraries and grazing behavior of small ruminants on mountain pastures in Mongolian Altai 81 multinutrient blocks, controlling internal parasites and enhancing utilization of alternate feed resources. International Atomic Energy Agency (IAEA-TECDOC-1495), 211– 218.
- Tserendash, S., 2000. Present conditions and strategies for management of Mongolian rangelands. Journal Erdem 38, 7–11.
- UNESCO International Bureau of Education. (2013). Glossary of Curriculum Terminology. available at Retrieved from: Glossary of Curriculum Terminology | International Bureau of Education (unesco.org)
- Undargaa, S., McCarthy, J.F., 2016. Beyond property: Co-management and pastoral resource access in Mongolia. World Development 77, 367–379.
- Van der Westhuisen, J.M., (2005). Marketing goat fibres. Small Ruminant Research 60 (2005) 215–218.
- Food and agricultural organization of the United Nations. (2017). Voluntary guidelines for sustainable soil management. Retrieved from <http://www.fao.org/3/a-bl813e.pdf>
- Food and agricultural organization of the United Nations. (2012). Voluntary guidelines on the responsible governance of tenure. ISBN:978-92-5-107277-6. Retrieved from <http://www.fao.org/tenure/voluntary-guidelines/en/>
- Food and agricultural organization of the United Nations. (2005). Animal welfare and intensification of animal production an alternative interpretation. ISBN 92-5-105386-3. Retrieved from <http://www.fao.org/3/a-a0158e.pdf>
- Food and agricultural organization of the United Nations. Approaches to risk management. Retrieved from <http://www.fao.org/3/i0412e/i0412e02.pdf>
- Livestock emergency guidelines and standards (2014). Published by Practical action publishing Ltd. Retrieved from <https://www.livestock-emergency.net/download-legs/>
- Thomas., L 2009. Entrepreneurial competence in agriculture: Characterization, identification, development and the role of the work environment. ISBN:978-90-8585-521-7. Retrieved from <https://core.ac.uk/download/pdf/29249966.pdf>
- Gerard. McElwee., (2005). developing entrepreneurial skills of farmers. Retrieved from http://www.esofarmers.org/fileadmin/esofarmers/documents/ESoFliteraturereview_000.pdf
- Wildlife conservation society (2010). Building capacity in conservation biology to protect Mongolia's natural heritage. conference proceedings. Retrieved from <https://mongolia.wcs.org/About-Us/Publications.aspx>
- Chará J., Reyes E., Peri P., Otte J., Arce E., Schneider F. 2019. Silvopastoral Systems and their Contribution to Improved Resource Use and Sustainable Development Goals: Evidence from Latin America. FAO, CIPAV and Agri Benchmark. Retrieved from <http://www.fao.org/3/ca2792en/ca2792en.pdf>



ХОЛБОО БАРИХ



Монгол Улс, Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 40,
50 мянгат Бакула Ринбүүчийн
гудамж, 4/8



+ 976 9903 7377



Info@mosard.mn

ЭМХЭТГЭН ГАРГАСАН
Төслийн баг

MOSARD